

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар № А/212/134

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын үед олон эх сурвалж ашиглан салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг цахим платформд суурилан хөгжүүлэх, салбарын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 28 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын Шадар
сайдын 2026 оны 07 сарын 02 ны
өдрийн А/212/164 тушаалын хавсралт

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕД
ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГООР
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах, салбар хооронд мэдээлэл шуурхай солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх, тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах, эрсдэлийн зураглал гаргах аргачлал боловсруулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Тодорхойлолт

2.1. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг;

2.2. “Үйл явдал” гэж хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулах бодит эсхүл болзошгүй нөхцөл байдал хянах, хор уршгийг бууруулах зорилгоор шуурхай арга хэмжээ авах шаардлага бий болсон тохиолдлыг;

2.3. “Үйл явдал идэвхтэй байх” гэж эрсдэлийн үнэлгээний дүнгээр дунд ба түүнээс дээш үнэлэгдсэн тохиолдлыг;

2.4. “Улсын хэмжээний үйл явдал” гэж нийслэл болон нэг буюу түүнээс дээш аймагт, эсхүл хоёр ба түүнээс дээш аймагт ижил төрлийн үйл явдал бүртгэгдэхийг;

2.5. “Орон нутгийн хэмжээний үйл явдал” гэж Нийслэл эсхүл нэг аймагт бүртгэгдэж байгаа үйл явдлыг;

2.6. “Эрсдэл” гэж үйл явдлаас үүдэлтэй хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал, гарч болзошгүй сөрөг дагаврын харилцан хамаарлаар тодорхойлогдох ойлголтыг;

2.7. “Дэгдэлт” гэж хамт олон, газар зүйн бүс нутаг эсхүл тодорхой хугацаанд аливаа нэг өвчин, үйл явдлын тохиолдлын тоо хэвийн түвшнээс давж бүртгэгдэхийг;

2.8. “Тэргүүлэх чиглэлийн байгууллага” гэж хариуцсан чиг үүргийн хүрээнд холбогдох нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, түүнд хүргэж болзошгүй үйл явдлын үед хариу арга хэмжээг төлөвлөх, удирдан чиглүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг хэлнэ.

2.9. “Эрсдэлийн үнэлгээ” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасныг;

2.10. “Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдал бүртгэгдэхэд богино хугацаанд хариу арга хэмжээ авахын тулд алгоритм ашиглан үнэлгээ хийхийг;

2.11. “Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ” гэж эрсдэлийг тодорхойлон, түүнд өртөх магадлалыг үнэлж, өртсөн тохиолдолд үүсэж болзошгүй эрүүл мэнд,

нийгэм, байгаль орчны үр дагаврыг чанарын болон тоон аргаар шинжлэн үнэлэх үйл явцыг хэлнэ;

2.12. “Эрсдэлийн түвшин” гэж аюулд өртөх магадлал болон гарч болох үр дагаврын “маш бага”, “бага”, “дунд”, “өндөр”, “маш өндөр” зэрэглэлийг;

2.13. “Эрсдэлийн үнэлгээний баг” гэж салбар хоорондын мэргэжлийн байгууллагын албан тушаалтнаас бүрдсэн эрсдэлийн үнэлгээ хийх бүрэлдэхүүнийг;

2.14. “Эрсдэлийн үнэлгээний ерөнхий асуулт” гэж тухайн үйл явдлын төрөл, явцаас хамааран цаашид өрнөх боломжит хувилбаруудыг тодорхойлж, томьёолсон зохиомжийг;

2.15. “Магадлалын болон үр дагаврын түвшнийг тогтоох жишиг асуумж” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарсан эрсдэлийн магадлал болон үр дагаврыг үнэлэхэд чиглүүлэх жишээ болгож байгаа багц асуултыг;

2.16. “Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага” гэж энэхүү дүрмийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохицуулахаар томилогдсон байгууллагыг;

2.17. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төв (ШУТ)” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, түүнд хүргэж болзошгүй үйл явдлыг тандах, хянах, хариу арга хэмжээ, нөөцийн хуваарилалтыг нэгдсэн удирдлагаар зохицуулах төвийг;

2.18. “Тохиолдлын удирдлагын тогтолцоо” (ТУТ) гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасныг;

2.19. “Идэвхжилийн зэрэг” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын эрсдэлийн үнэлгээний дүнд тулгуурлан авч, хэрэгжүүлэх хариу арга хэмжээний тогтоосон хэм хэмжээг;

2.20. “Хариу арга хэмжээ” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасныг;

2.21. “Шуурхай хариу арга хэмжээний баг” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдал бүртгэгдсэн үед талбар дээр хариу арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий салбар хоорондын мэргэжлийн бүрэлдэхүүнийг;

2.22. “Эрсдэлийн харилцаа холбоо” гэж нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед иргэд, олон нийт, мэргэжлийн байгууллага, шийдвэр гаргагчдыг үнэн зөв мэдээллээр цаг тухайд нь хангаж, хариу арга хэмжээ, эрсдэлийг бууруулах шийдвэр гаргахад нөлөөлөх үйл явцыг.

Гурав.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах, салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох

3.1. Ерөнхий зохицуулалт

3.1.1.Салбар хоорондын мэргэжлийн байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлыг эрт илрүүлэх зорилгоор хариуцсан чиг үүргийн хүрээнд олон эх сурвалжит тандалтыг тогтмол хийж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцоно.

3.1.2.Тэргүүлэх болон хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх байгууллага нь тайван үе болон ноцтой нөхцөл байдлын үед мэдээ, мэдээлэл солилцох асуудал хариуцсан албан тушаалтныг томилж, түүний холбоо барих мэдээллийг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага болох Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв (ӨХСҮТ)-д хүргүүлнэ. Холбогдох албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд мэдээллийг тухай бүр шинэчлэн хүргүүлнэ.

3.1.3.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдалд дараах үйл явдлыг хамааруулж ойлгоно. Үүнд:

- Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэж буй халдварын тохиолдол
- Зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол
- Мал, гэрийн тэжээвэр амьтны халдварт өвчний тохиолдол, зүй бус хорогдол
- Зэрлэг амьтны зүй бус хорогдол
- Хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт
- Хоол, хүнсний шалтгаант хордлого
- Агаарын аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт
- Усны аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт
- Хөрсний аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт
- Цацрагийн осол, хордлого
- Химийн бодисын алдагдал, осол, хордлого
- Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын алдагдал
- Хортон шавж, мэрэгчийн тархалт
- Байгалийн аюулт үзэгдлийн (үер, гал түймэр, ган, зуд, газар хөдлөлт г.м) улмаас үүссэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал

3.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдлыг бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх

3.2.1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын мэдээллийг хүлээн авах, бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллага хариуцан гүйцэтгэх ба Маягт 1-ийн дагуу бүртгэнэ.

3.2.2.Дээрх мэдээлэл нь Маягт 2-д заасан тодорхойлолтын ямар төрлийн үйл явдалд хамаарч байгааг тогтоож баталгаажуулна.

3.2.3.Мэдээллийг баталгаажсан даруйд дээд шатны байгууллагад мэдээлэх шаардлагатай эсэхийг Маягт 3-д заасан шалгуураар үнэлнэ.

3.2.4.Мэдээлэх шаардлагатай эсэхийг үнэлэх шалгуурт 1 ба түүнээс дээш удаа “тийм”, эсхүл “тодорхойгүй” гэж хариулсан тохиолдолд “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдал” гэж үзнэ.

3.2.5.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын мэдээг 2 цагийн дотор Маягт 4-ийн дагуу бэлтгэж, цахимаар/утсаар удирдах дээд байгууллагын Шуурхай удирдлагын төв, нэгж эсхүл холбогдох асуудал хариуцсан албан тушаалтанд мэдээлнэ.

3.2.6.Тэргүүлэх чиглэлийн байгууллага нь бүртгэгдсэн үйл явдлыг нэгтгэж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

3.3. Мэдээлэл солилцох

3.3.1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын мэдээллийг бүртгэж, эрсдэлийн түргэвчилсэн болон нөхцөл байдлын үнэлгээний дүнг үндэслэн мэдээ, мэдээллийг удирдах дээд байгууллага болон хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллага (цаашид мэдээлэл солилцох байгууллага гэх)-д дараах давтамжтайгаар мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

- Эрсдэлийн үнэлгээний дүнгээр “маш бага”, “бага” үнэлэгдсэн тохиолдолд мэдээлэл солилцох байгууллагад мэдээлж, үйл явдлыг хаана.
- Эрсдэлийн түргэвчилсэн болон нөхцөл байдлын үнэлгээний дүнгээр “дунд” буюу үйл явдал идэвхтэй байх үед шинэчлэгдсэн мэдээг мэдээлэл солилцох байгууллагад 24 цагт 1 удаа мэдээлнэ.
- Эрсдэлийн түргэвчилсэн болон нөхцөл байдлын үнэлгээний дүнгээр “өндөр” эсхүл “маш өндөр” гэж тогтоосон тохиолдолд өдөр бүрийн 10.00, 16.00, 22.00 цагт мэдээллийг шинэчлэн мэдээлэл солилцох байгууллагуудад мэдээлнэ.
- Эрсдэлийн үнэлгээний дүнгээр эрсдэлийн зэрэг буурч, үйл явдлын өрнөл тогтвортой болсон тохиолдолд мэдээллийг 24 цагт нэг удаа шинэчлэн мэдээлнэ.

3.4. Үйл явдлыг бүртгэх, мэдээлэх маягт 1.

№	Талбарын нэр	Мэдээлэл бөглөх хэсэг
1	Бүртгэгдсэн огноо	он ___ / сар ___ / өдөр ___
2	Мэдээлэгдсэн огноо	он ___ / сар ___ / өдөр ___
3	Цар хүрээ	<input type="checkbox"/> Дотоод <input type="checkbox"/> Гадаад
4	Бүртгэсэн ажилтны овог, нэр	
5	Давтамж	<input type="checkbox"/> Эхний <input type="checkbox"/> Шинэчилсэн <input type="checkbox"/> Сүүлийн
6	№ (төлөв)	<input type="checkbox"/> Нээв <input type="checkbox"/> Шинэчлэв <input type="checkbox"/> Хаав
7	Үйл явдлын төрөл	(Журманд заасан 18 төрлөөс)
8	Үйл явдлын нэр	
9	Бүртгэлийн дугаар	
10	Тэргүүлэх чиглэлийн байгууллага	
11	Засаг захиргааны нэгж	Улс / Аймаг / Нийслэл
12	Сум / Дүүрэг	
13	Баг / Хороо	
14	Байршил	
15	Эх сурвалжийн төрөл	<input type="checkbox"/> Албан <input type="checkbox"/> Албан бус
16	Эх сурвалж	
17	Товч мэдээлэл	
18	Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дүн	<input type="checkbox"/> Маш бага <input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр <input type="checkbox"/> Маш өндөр
19	Нөхцөл байдлын үнэлгээний дүн	<input type="checkbox"/> Маш бага <input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Дунд <input type="checkbox"/> Өндөр <input type="checkbox"/> Маш өндөр
20	Төлөв	<input type="checkbox"/> Батлагдсан <input type="checkbox"/> Үгүйсгэгдсэн <input type="checkbox"/> Тодруулж байгаа <input type="checkbox"/> Шалтгаан тогтоогдоогүй
21	Хариу арга хэмжээ	
22	Холбоос	
23	Үйл явдал мөн эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

Маягт 2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдлыг тодорхойлоход ашиглах мэдээлэл

№	Үйл явдлын төрөл	Үйл явдлыг тодорхойлоход ашиглах мэдээлэл
1.	Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэж буй халдварын тохиолдол	- Шалтгаан тодорхойгүй өвчин, нас баралтын тохиолдлын мэдээ - Шинэ болон сэргэж буй халдварын тохиолдлын мэдээ - Халдварт өвчний дэгдэлтийн мэдээ
2.	Зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол	Зоонозын шалтгаант халдварын хүний өвчний мэдээ
3.	Мал, гэрийн тэжээвэр амьтны халдварт өвчний тохиолдол, зүй бус хорогдол	- Хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэдэг зоонозын халдварт өвчний тохиолдлын мэдээ - Мал, гэрийн тэжээвэр амьтны шалтгаан тодорхойгүй, зүй бус хорогдлын мэдээ
4.	Зэрлэг амьтны зүй бус хорогдол	Зэрлэг амьтан олноор хорогдсон талаарх мэдээ
5.	Хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнд нийлүүлсэн талаарх мэдээ
6.	Хоол, хүнсний шалтгаант хордлого	Хоол хүнсээр дамжсан байж болох хордлого, халдварын сэжигтэй тохиолдлын мэдээ
7.	Агаарын аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт	Агаарын аюулгүй байдлын үзүүлэлт босго түвшнээс давсан тухай мэдээ
8.	Усны аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт	Усны аюулгүй байдлын үзүүлэлт босго түвшнээс давсан тухай мэдээ
9.	Хөрсний аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт	Хөрсний аюулгүй байдлын үзүүлэлт босго түвшнээс давсан тухай мэдээ
10.	Цацрагийн осол, хордлого	- Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, хадгалах, ашиглах, булшлах, түүнчлэн цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, рентген аппаратыг ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага зөрчигдсөний улмаас гэмтэл, доголдол үүсч, ионжуулагч цацраг орчинд тархах, улмаар хүн, мал, амьтан болон хүрээлэн буй орчинд бодит болон болзошгүй аюул, сөрөг нөлөө учруулсан тохиолдлын мэдээ - Цацраг идэвхт бодисын нөлөөтэй байж болзошгүй эмгэгт байдал үүссэн тухай мэдээ
11.	Химийн бодисын алдагдал, осол, хордлого	- Химийн бодис орчинд алдагдаж байгаа талаарх мэдээ - Хүний эрүүл мэндэд хор нөлөө үзүүлж болзошгүй химийн бодис хөрс, ус, агаарт алдагдаж байгаа талаарх мэдээ - Химийн бодисын нөлөөтэй байж болзошгүй эмгэгийн бүртгэгдсэн тохиолдлын тоо босго үзүүлэлт давсан тухай мэдээ
12.	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын алдагдал	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал ил задгай хаягдсан талаарх мэдээ
13.	Хортон шавж, мэрэгчийн тархалт	Хортон шавж, мэрэгчийн тоошил нэмэгдэж байгаа болон зүй бус, гэнэтийн тархалтын талаарх мэдээ
14.	Байгалийн аюулт үзэгдлийн (үер, гал түймэр, ган, зуд, газар хөдлөлт г.м) улмаас үүссэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал	- Байгалийн аюулт үзэгдэлд өртсөн хүн, мал, объектын мэдээ - Өртсөн хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх мэдээлэл

Маягт 3. Мэдээлэх шаардлагатай эсэхийг үнэлэх шалгуур

№	Асуулт	Хариулт		
		Тийм	Үгүй	Тодорхойгүй
Халдварт өвчин байж болзошгүй үйл явдал				
1.	Үйл явдал нь хэвийн бус шинжтэй байна уу?			
2.	Манай улс/орон нутагт нутагшмал бус халдварт өвчин үү?			
3.	Шалтгаан тодорхойгүй өвчлөл эсхүл нас баралтын хоёр буюу түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үү?			
4.	Хүн амыг хамарсан халдварт өвчний дэгдэлт болж тархах магадлалтай юу?			
5.	Тохиолдлын тоо өмнө бүртгэгдэж байсан статистик тоон мэдээнээс их байна уу?			
6.	Халдвар нь өмнө мэдэгдэж байснаас илүү эмнэлзүйн хүнд эсхүл өвөрмөц явцтай байгаа тухай нотолгоо байна уу?			
7.	Өртсөн хүн ам эрүүл мэндийн зохих тусламж, үйлчилгээг авч чадахгүй байна уу?			
8.	Аялал жуулчлал, худалдаанд нөлөөлөх үү?			
Байгалийн аюулт үзэгдлийн улмаас үүссэн үйл явдал				
1.	Олон хүний амь нас эрсдэлд өртсөн үү?			
2.	Байгалийн аюулт үзэгдлийн улмаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сөргөөр нөлөөлсөн үү?			
3.	Үндэсний хэмжээнд эсхүл тухайн орон нутгийн хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжсэн үү?			
4.	Эрсдэлд өртсөн хүмүүс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авч чадахгүй байна уу?			
5.	Олныг хамарсан арга хэмжээтэй холбоотой бүртгэгдсэн (байршил, цаг хугацаа, өртсөн хүмүүс холбоо хамааралтай) үү?			
6.	Хүн амын эрүүл мэндэд дам сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юу?			
Хоол, хүнсээр дамжих халдвар үүссэн талаарх үйл явдал				
1.	Үндэсний хэмжээнд эсхүл тухайн орон нутгийн хэмжээнд хүн амыг хамарсан дэгдэлт үүссэн үү?			
2.	Үйл явдал нь зах зээлд өргөн хэрэглэгддэг хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой юу?			
3.	Өртсөн хүн ам эрүүл мэндийн зохих тусламж, үйлчилгээг авч чадахгүй байна уу?			
4.	Үндэсний хэмжээнд эсхүл тухайн орон нутгийн хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжсэн үү?			
5.	Инфосангийн шугамаар үйл явдал мэдээлэгдсэн үү?			
6.	Аялал жуулчлал, худалдаанд нөлөөлөх үү?			
Бусад шалтгаант үйл явдал				
1.	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай агаар, ус, хөрс бохирдуулах, хүнсний аюулгүй байдал, амьтны эрүүл мэндтэй холбоотой үйл явдал уу?			
2.	Тухайн үйл явдал тасралтгүй үргэлжилж байна уу?			
3.	Үндэсний хэмжээнд эсхүл тухайн орон нутгийн хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжсэн үү?			
4.	Хүн амын эрүүл мэндэд дам сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юу?			
5.	Өртсөн хүн ам эрүүл мэндийн зохих тусламж, үйлчилгээг авч чадахгүй байна уу?			
6.	Аялал жуулчлал, худалдаанд нөлөөлөх үү?			
Гадаад улс, оронд бүртгэгдэж байгаа үйл явдал				
1.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдлын талаар ДЭМБ эсхүл тухайн улсын Засгийн газрын албан мэдээлэл үү?			

2.	Шинэ/шалтгаан тодорхойгүй халдварын кластер өвчлөлтэй холбоотой мэдээлэл үү?			
3.	Шинэ/шалтгаан тодорхойгүй халдварын нас баралттай холбоотой мэдээлэл үү?			
4.	Өндөр хоруу чанартай вирусээр үүсгэгдсэн халдвартай холбоотой мэдээлэл үү?			

Маягт 4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдлын мэдээлэх хуудас

№	Ерөнхий	Дэлгэрэнгүй мэдээлэл
1.	Мэдээний төрөл	<input type="checkbox"/> Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэж буй халдварын тохиолдол <input type="checkbox"/> Зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол <input type="checkbox"/> Мал, гэрийн тэжээвэр амьтны халдварт өвчний тохиолдол <input type="checkbox"/> Мал, гэрийн тэжээвэр амьтдын зүй бус хорогдол <input type="checkbox"/> Зэрлэг амьтны зүй бус хорогдол <input type="checkbox"/> Хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт <input type="checkbox"/> Хоол, хүнсний шалтгаант хордлого <input type="checkbox"/> Агаарын аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт <input type="checkbox"/> Усны аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт <input type="checkbox"/> Хөрсний аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт <input type="checkbox"/> Цацрагийн осол <input type="checkbox"/> Цацрагийн хордлого <input type="checkbox"/> Химийн бодисын алдагдал <input type="checkbox"/> Химийн бодисын осол <input type="checkbox"/> Химийн хордлого <input type="checkbox"/> Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын алдагдал <input type="checkbox"/> Хортон шавж, мэрэгчийн тархалт <input type="checkbox"/> Байгалийн аюулт үзэгдлийн (үер, гал түймэр, ган, зуд, газар хөдлөлт г.м) улмаас үүссэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал
2.	Үйл явдлын нэр	-----
3.	Өртөлт	<input type="checkbox"/> Хүний тоо ___ <input type="checkbox"/> Малын тоо ____ <input type="checkbox"/> Амьтны тоо ____ <input type="checkbox"/> Орчин (газар нутаг) Талбайн хэмжээ ____ <input type="checkbox"/> Объектын тоо ____ <input type="checkbox"/> Объектын үйл ажиллагааны төрөл ____
4.	Өвчилсөн	<input type="checkbox"/> Хүний тоо ___ Малын тоо ___ Амьтны тоо ___
5.	Нас барсан/хорогдсон	<input type="checkbox"/> Хүний тоо ____ <input type="checkbox"/> Малын тоо ____ <input type="checkbox"/> Амьтны тоо ____
6.	Эвдэрсэн, сүйрсэн	<input type="checkbox"/> Объектын тоо ____
7.	Байршил	<input type="checkbox"/> Хот, дүүрэг, хороо/Аймаг, сум, баг, газрын нэр: <input type="checkbox"/> Газрын зургаар бол (Google map) <input type="checkbox"/> Газрын зураггүй бол координацын солбилцол: Уртраг _____ Өргөрөг _____
8.	Үйл явдал бүртгэгдсэн огноо онсарөдөрцаг мин
9.	Мэдээлэл хүлээж авсан огноо онсарөдөрцаг мин
10.	Мэдээлэл шинэчлэгдсэн огноо онсарөдөрцаг мин
11.	Мэдээний хүрээ	<input type="checkbox"/> Гадаад <input type="checkbox"/> Дотоод
12.	Мэдээний эх сурвалж	<input type="checkbox"/> Албан <input type="checkbox"/> Албан бус (холбоос)
13.	Мэдээлсэн	Байгууллага Албан тушаалтны нэр Утас

		Цахим хаяг
14.	Мэдээлэл хүлээж авсан	Байгууллага Албан тушаалтны нэр Утас Цахим хаяг
15.	Сорьц/дээж авсан эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
16.	Сорьц/дээжийн төрөл	
17.	Шинжилсэн лабораторийн нэр	
18.	Лабораторийн шинжилгээний дүн	
19.	Үйл явдлын дэлгэрэнгүй мэдээлэл	Үйл явдлын өрнөлийн талаарх мэдээлэл
		Өртсөн хүн ам зүйн мэдээлэл (нас, хүйс, ажил, мэргэжил г.м)
		Тархвар судлалын мэдээлэл
		Эмнэлзүйн мэдээлэл, шинж тэмдэг
20.	Хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ	

Шаардлагатай бол дэгдэлтийн судалгаа болон дэлгэрэнгүй мэдээллийг тусад нь хавсаргана.

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх

4.1. Ерөнхий зохицуулалт

4.1.1.Өвөрмөц онцлог бүхий зарим эрсдэлийн үед тусгайлсан аргачлалыг ашиглаж болно.

4.1.2.Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу хийх бөгөөд холбогдох мэдээллийг харилцан солилцож ажиллана.

4.1.3.Цацрагийн ослын үед Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө”-ний дагуу холбогдох байгууллагууд хамтран ажиллана.

4.2.Эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээнд оролцох салбар хоорондын байгууллага

4.2.1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээнд дараах байгууллагууд тэргүүлэх, хамтрах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр оролцоно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээнд оролцох байгууллага

№	Үйл явдлын төрөл	Түвшин	Чиг үүргийн байгууллага		
			Тэргүүлэх чиглэлийн	Хамтрах	Дэмжлэг үзүүлэх
1.	Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэн тархаж буй халдварын тохиолдол	Үндэсний	ӨХСҮТ	ЭМЯ, ОБЕГ, ХХЕГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, СЯ, ГХЯ, ХЗДХЯ, ЗТЯ, БЯ, БХЯ, БОУАӨЯ, ТЕГ, ЦЕГ, ИНЕГ, МЭЕГ, ГЕГ, СХЗГ, холбогдох яам, агентлаг, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага

		Аймаг/ нийслэл	ЭМГ	ОБГ, ОБХ, ЗӨСТ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, БОГ, ХХААГ, МЭГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Гаалийн газар, хороо, холбогдох байгууллага
2.	Зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол	Үндэсний	ӨХСҮТ	ЭМЯ, ХХААХҮЯ, МЭЭГ, ОБЕГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, СЯ, ГХЯ, БОУАӨЯ, ХЗДХЯ, ЗТЯ, БЯ, БХЯ, ТЕГ, ЦЕГ, ГЕГ, холбогдох яам, агентлаг, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага
		Аймаг/ нийслэл	ЗӨСТ (ЗӨСТ-гүй аймагт ЭМГ)	ОБГ, ЭМГ, ХХААГ, МЭГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, БОГ, ХХААГ, МЭГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Тагнуулын газар, Гаалийн газар, Цагдаагийн газар, хороо, холбогдох байгууллага
3.	Мал, гэрийн тэжээвэр амьтны халдварт өвчний тохиолдол, зүй бус хорогдол	Үндэсний	МЭЭГ	ХХААХҮЯ, ӨХСҮТ, ОБЕГ, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, СЯ, БОУАӨЯ, ЭМЯ, ЗТЯ, ТЕГ, ГЕГ, холбогдох яам, агентлаг
		Аймаг/ нийслэл	МЭГ	ХХААГ, ЗӨСТ, ОБГ, БОГ, нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Гаалийн газар, хороо, холбогдох байгууллага
4.	Зэрлэг амьтны зүй бус хорогдол	Үндэсний	БОУАӨЯ	ХХААХҮЯ, ОБЕГ, ӨХСҮТ, Нутгийн захиргааны байгууллага	УОК, СЯ, ТЕГ, ЦЕГ, ГЕГ, холбогдох яам, агентлаг, олон улсын байгууллага
		Аймаг/ нийслэл	БОГ	ХХААГ, МЭГ, ОБГ, ЗӨСТ, Нутгийн захиргааны байгууллага	АОК, НОК, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Гаалийн газар, хороо, холбогдох байгууллага
5.	Хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт	Үндэсний	ХХААХҮЯ	ЭМЯ, СХЗГ, ӨХСҮТ, ГЕГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, ГХЯ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, холбогдох яам, агентлаг, олон улсын байгууллага
		Аймаг/ нийслэл	ХХААГ	ЭМГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Гаалийн газар, хороо, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, ОБГ, Тагнуулын газар, Цагдаагийн газар, холбогдох байгууллага

6.	Хоол, хүнсний шалтгаант хордлого	Үндэсний	ӨХСҮТ	ЭМЯ, ХХААХҮЯ, СХЗГ, ХАБҮЛЛ, ГЕГ, МЭЭГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, ОБЕГ, холбогдох яам, агентлаг, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага
		Аймаг/ нийслэл	ЭМГ	ХХААГ, СХХ, МЭГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, холбогдох байгууллага
7.	Агаар, ус, хөрсний аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт	Үндэсний	БОУАӨЯ ӨХСҮТ	ЭМЯ, ЦУОШГ, Усны газар, ХАБҮЛЛ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, ОБЕГ, ГЕГ, холбогдох яам, агентлаг
		Аймаг/ нийслэл	БОГ ЭМГ	СХХ, Цаг уур орчны газар, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, холбогдох байгууллага
8.	Цацрагийн осол, хордлого	Үндэсний/ Аймаг, нийслэл	ЦЭКАА	ЭМЯ, АҮЭБЯ, ОБЕГ, ӨХСҮТ, БХЯ, ЦЕГ, АМГТГ, ХАБҮЛЛ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, СЯ, ЭЗХЯ, ЗТЯ, ТЕГ, ГЕГ, ЦЕГ, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага
9.	Химийн бодисын алдагдал, осол, хордлого	Үндэсний	ОБЕГ ӨХСҮТ	БХЯ, БОУАӨЯ, ГЕГ, ЦЕГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, ЭЗХЯ, СЯ, ЗТЯ, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага
		Аймаг/ нийслэл	ОБГ ЭМГ	БОГ, Гаалийн газар, хороо, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, холбогдох байгууллага
11.	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын алдагдал	Үндэсний	ӨХСҮТ	ЭМЯ, БОУАӨЯ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, ЗТЯ, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага
		Аймаг/ нийслэл	ЭМГ	ЗӨСТ, БОГ, Нутгийн захиргааны байгууллага,	АОК, НОК, холбогдох байгууллага

				хяналт, шалгалтын байгууллага	
12.	Хортон шавж, мэрэгчийн тархалт	Үндэсний	БОУАӨЯ ӨХСҮТ	ХХААХҮЯ, ЭМЯ, ОБЕГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, НОК, ЗТЯ, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага
		Аймаг/ нийслэл	БОГ	ХХААГ, ОБГ, Нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, холбогдох байгууллага
13.	Байгалийн аюулт үзэгдлийн (үер, гал түймэр, ган, зуд, газар хөдлөлт г.м) улмаас үүссэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал	Үндэсний	ОБЕГ	Улсын албад, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	УОК, нутгийн захиргааны байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага
		Аймаг/ нийслэл	ОБГ	ЭМГ, БОГ, МЭГ, ХХААГ, нутгийн захиргааны байгууллага, хяналт, шалгалтын байгууллага	АОК, НОК, холбогдох байгууллага

4.3.Эрсдэлийн үнэлгээ хийх давтамж, хэлбэр

4.3.1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрсдэлийн үнэлгээг дараах давтамжтайгаар хийнэ. Үүнд:


- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдал гэж үзсэнээс хойш эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 4 цагийн дотор тэргүүлэх чиглэлийн байгууллага гүйцэтгэнэ.
- Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр эрсдэлийн түвшин “дунд” болон түүнээс дээш үнэлэгдсэн тохиолдолд тэргүүлэх чиглэлийн байгууллага нь дэмжих, хамтрах байгууллагуудын оролцоог ханган эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг 24 цагийн дотор хийнэ.
- Тэргүүлэх чиглэлийн байгууллагын саналаар үйл явдлын цар хүрээ, өрнөлөөс хамаарч, нөхцөл байдлын үнэлгээг үйл явдал дуусах хүртэл хугацаанд давтан хийнэ.

4.3.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын үеийн эрсдэлийн үнэлгээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд:


- Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ
- Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ

4.3.3.Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг халдварт болон зоонозын өвчний шалтгаант үйл явдал, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын тохиолдлын үед алгоритм 1, бусад үйл явдлын үед алгоритм 2-ын дагуу тэргүүлэх чиглэлийн байгууллага хийнэ.

Алгоритм 1. Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэн тархаж буй халдварын тохиолдол, зоонозын шалтгаант үйл явдлын үед түргэвчилсэн үнэлгээ хийх алгоритм



Алгоритм 2. Бусад үйл явдлын үед эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх алгоритм



4.4.Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дүнд үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эрсдэлийн түвшин	Идэвхжилийн зэрэг	Авах арга хэмжээ
Маш бага эрсдэлтэй	0	<ul style="list-style-type: none"> - Тухайн үйл явдлыг хаах; - Холбогдох тушаал, зааврын дагуу тайван цагийн горимоор ажиллах;
Бага эрсдэлтэй	0	<ul style="list-style-type: none"> - Үйл явдлыг үргэлжлүүлэн ажиглах; - Холбогдох тушаал, зааврын дагуу тайван цагийн горимоор ажиллах; - Үйл явдлын мэдээллийг хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудад хүргүүлэх;
Дунд	I	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг 24 цагийн дотор тэргүүлэх чиглэлийн байгууллага тэргүүлэн салбар хоорондын байгууллагын оролцоог ханган хийж, тайлан, зөвлөмж гаргах; - Шуурхай хариу арга хэмжээний багийг талбарт ажиллуулах эсэхийг хэлэлцэх, бэлэн байдлыг хангах; - Тандалт, лаборатори, эмнэлзүйн менежмент болон холбогдох эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, урвалж, оношлуур зэрэг шаардлагатай дэмжлэгийг үйл явдал гарсан газарт үзүүлэх; - Мэдээлэл солилцох байгууллагуудад үйл явдлын мэдээллийг хуваалцах;
Өндөр	II	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг давтан хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Шуурхай хариу арга хэмжээний багийг талбарт ажиллуулах; - Үндэсний эсхүл орон нутгийн түвшинд НЭМ-ийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг идэвхжүүлэх тухай хэлэлцэх, бэлэн байдлыг хангах; - Мэдээлэл солилцох байгууллагуудад үйл явдлын мэдээллийг хуваалцах;
Маш өндөр	III	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг давтан хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Шуурхай хариу арга хэмжээний багийг талбарт ажиллуулах; - Үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг идэвхжүүлэх; - Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас дэмжлэг хүсэх тухай хэлэлцэх; - Мэдээлэл солилцох байгууллагуудад үйл явдлын мэдээллийг хуваалцах;

4.5.Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний тайланг дараах загвараар бичнэ.

Үйл явдлын нэр: _____	Үнэлгээний хамрах хүрээ: _____ улс/аймаг/нийслэл/дүүрэг/сум
Огноо: _____	Эрсдэлийн түвшин: _____
Үйл явдлын тухай ерөнхий мэдээлэл: (Үйл явдлын бичиглэл судалгаа, хариу арга хэмжээ, нөөц, тухай мэдээлэл г.м)	
Үнэлгээний тухай: (Үнэлгээг хийсэн үйл явц болон үнэлгээнд оролцсон гишүүдийн тухай товч мэдээлэл)	
Үнэлгээний алгоритм	

Үнэлгээний дүнд итгэх түвшин: (Үнэлгээнд ашигласан мэдээлэлд үндэслэн үнэлгээний баг нь эрсдэлийн үнэлгээний гарсан дүнд итгэх итгэлийн түвшинг (маш бага, бага, дунд, өндөр, маш өндөр) хэлэлцэн тодорхойлно)

Зөвлөмж: (Үнэлгээний багаас санал болгох цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт)

4.6. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарч тэргүүлэх чиглэлийн байгууллага удирдан салбар хоорондын мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан гүйцэтгэнэ.

4.7. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг дараах дарааллын дагуу хийнэ.

Үүнд:

- үнэлгээний багийг бүрдүүлэх;
- үнэлгээний ерөнхий асуулт, асуумжийг үйл явдалд нийцүүлэн шинэчлэн боловсруулах;
- үнэлгээнд ашиглах мэдээлэл цуглуулах;
- үнэлгээ хийх;
- үнэлгээний тайлан бичих, зөвлөмж боловсруулах.

4.8. Үнэлгээний багийг бүрдүүлэх:

4.8.1. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамааран энэхүү журмын хоёрдугаар хавсралтын 3.1-т заасан тэргүүлэх чиглэлийн байгууллага нь 9-өөс доошгүй гишүүнтэй эрсдэлийн үнэлгээний баг (цаашид “баг” гэх) байгуулна.

4.8.2. багт ажиллах мэргэжилтэн нь тухайн салбарт ажиллаж байгаа, дадлага, туршлагатай байна.

4.8.3. тэргүүлэх чиглэлийн байгууллагаас оролцож байгаа гишүүдийн тоо нийт гишүүдийн 50 хувиас хэтрэхгүй байна.

4.8.4. эрсдэлийн үнэлгээг тэргүүлэх чиглэлийн байгууллагын удирдах албан тушаалтан ахалж, дадлага, туршлага бүхий мэргэшсэн мэргэжилтнийг чиглүүлэгчээр томилно.

4.8.5. багийн ахлагч нь үнэлгээ хийх хугацааг товлон хөтөлбөр батлах, үнэлгээг удирдах, тайлан, зөвлөмж, дүгнэлтийг хянаж баталгаажуулна.

4.8.6. багийн чиглүүлэгч нь үнэлгээний явцыг удирдаж, асуумжийн дагуу удирдан чиглүүлэх, гишүүдийн хариулт, нэмэлт тайлбар, үнэлгээний дүнг нэгтгэн боловсруулж тайлан, зөвлөмжийг нэгтгэнэ.

4.8.7. багийн гишүүд нь үнэлгээний ерөнхий асуулт болон тусгай асуумжид санал өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран бэлтгэх, үнэлгээний үед асуумжийн дагуу зохих хариулт, нэмэлт тайлбар өгнө.

4.9. Үнэлгээний ерөнхий асуулт боловсруулах:

4.9.1. багийн гишүүд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрөл, өрнөлд нийцүүлэн эрсдэлийн үнэлгээний “ерөнхий асуулт”-ыг боловсруулан гаргана.

4.9.2. үйл явдлын төрөлд нийцүүлэн энэхүү журмын Маягт 1-4-т заасан магадлал, үр дагаврын түвшин тогтоох асуумжаас сонгон эрсдэлийн үнэлгээнд ашиглана.

4.9.3.тэргүүлэх чиглэлийн байгууллага болон багийн гишүүд нь үйл явдлын явц, цар хүрээ, өрнөлөөс хамаарч магадлал, үр дагаврын түвшнийг тогтоох асуумжийн асуултыг өөрчилж болно.

4.9.4.үнэлгээнд ашиглах магадлал, үр дагаврын түвшнийг тогтоох асуумжийг багийн гишүүдийн олонхын саналаар батална.

4.10.Үнэлгээний мэдээлэл цуглуулах:

4.10.1.тэргүүлэх чиглэлийн байгууллага нь эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийхэд ашиглах дараах мэдээ, мэдээллийг бэлтгэж, үнэлгээний багийн гишүүдэд урьдчилан хүргүүлнэ. Үүнд:

-Үйл явдлын суурь мэдээлэл (хүн ам зүйн мэдээлэл, үйл явдлын давтамж, олон жилийн хандлага, тархвар зүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавх, нөөц болон бусад холбогдох мэдээлэл);

-Нөхцөл байдлын мэдээлэл (газарзүйн байршил, өртөлт, хугацаа, өвчлөлийн тоо, нас, хүйс г.м);

-Нэмэлт мэдээлэл (үйл явдал болсон газрын дэд бүтэц, харилцаа холбоо, үйлдвэрлэл, зам тээвэр, хүүхдийн байгууллага, хүнсний худалдаа, үйлчилгээ г.м);

-Холбогдох стандарт, удирдамж, журам, заавар зэрэг эрх зүйн баримт бичиг;

-Бусад шаардлагатай мэдээлэл.

4.11.Үнэлгээ хийх:

4.11.1.багийн гишүүд магадлал болон үр дагаврын асуулт бүрийг дэлгэрэнгүй хэлэлцэж, үйл явдлын суурь, нөхцөл байдлын мэдээлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний түвшин, чадавх, өөрийн мэдлэг, туршлагад үндэслэн “маш бага-маш өндөр” буюу 1-5 онооны зарчмаар өгнө.

4.11.2.багийн гишүүн бүр эрсдэлийн үнэлгээний магадлалын болон үр дагаврын асуулт тус бүрд “Маш бага”, “Бага”, “Дунд”, “Өндөр”, “Маш өндөр” гэсэн түвшнээс тохирох түвшнийг сонгон харгалзах оноог өгнө (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эрсдэлийн түвшин тус бүрд харгалзах онооны хүснэгт

Түвшин	Оноо
Маш бага	1
Бага	2
Дунд	3
Өндөр	4
Маш өндөр	5

4.11.3.чиглүүлэгч нь багийн гишүүн тус бүрийн үнэлгээг тэмдэглэн авч, олонхоос ялгаатай хариулт өгсөн гишүүнээс үндэслэл, нэмэлт тайлбарыг заавал авна.

4.11.4.багийн гишүүн өгсөн үнэлгээний оноогоо нэг удаа өөрчилж болно.

4.11.5.хэрэв үнэлгээнд нэг байгууллагаас олон гишүүн оролцож байгаа тохиолдолд хоорондоо ярилцаж, зөвшилцсөний үндсэн дээр байгууллага төлөөлөн нэг оноо өгч болно.

4.11.6.гишүүдийн өгсөн онооны дундаж (Гишүүн 1+Гишүүн 2+...../нийт гишүүдийн тоо)-ийг тооцон гаргана.

4.11.7.багийн гишүүдийн онооны дундаж, харгалзах эрсдэлийн түвшнийг дараах хүснэгтэд зааснаар тогтооно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Эрсдэлийн оноо, түвшин, хувь

Эрсдэлийн оноо	Түвшин	Хувь
1-1.9	Маш бага	0-39%
2-2.9	Бага	40-59%
3-3.9	Дунд	60-79%
4-4.5	Өндөр	80-90%
4.6-5	Маш өндөр	91-100%

4.11.8. магадлал болон үр дагаврын түвшнийг эрсдэлийн үнэлгээний матрицад байршуулан, тухайн үйл явдлын эрсдэлийн түвшнийг тогтооно (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний матриц

		Үр дагаврын түвшин				
		Маш бага (1-1.9)	Бага (2-2.9)	Дунд (3-3.9)	Их (4-4.5)	Маш их (4.6-5)
Магадлалын түвшин	Маш өндөр (4.6-5)	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр	Маш өндөр
	Өндөр (4-4.5)	Маш бага	Бага	Өндөр	Өндөр	Маш өндөр
	Дунд (3-3.9)	Маш бага	Бага	Дунд	Өндөр	Өндөр
	Бага (2-2.9)	Маш бага	Бага	Бага	Дунд	Дунд
	Маш бага (1-1.9)	Маш бага	Маш бага	Бага	Дунд	Дунд

4.11.9. чиглүүлэгч үнэлгээний тайланг үнэлгээ хийснээс хойш 4 цагийн дотор бичиж, багийн гишүүдэд хүргүүлэн санал, зөвлөмжийг авна.

4.11.10. багийн гишүүдийн саналын дагуу засварласны дараа багийн ахлагчид хянуулж, баталгаажуулна.

4.11.11. эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний тайланг 24 цагийн дотор холбогдох байгууллагад хүргүүлнэ.

4.11.12. тайланг дараах бүтцийн дагуу бичнэ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрөл
- Багийн бүрэлдэхүүний нэр, байгууллага, албан тушаал
- Үнэлгээ хийсэн огноо, цаг
- Үйл явдлын талаарх суурь мэдээлэл
- Үйл явдлын дэлгэрэнгүй мэдээлэл (бичиглэл судалгаа)
- Эрсдэлийн магадлал, үр дагаврын түвшнийг тогтоох эцсийн онооны нийтлэг тайлбар (суурь мэдээллээ бэлтгэх, өртөлт, нөлөөлөгч хүчин зүйлсийг гарган асуултыг багцлах)
- Дүгнэлт
- Хариу арга хэмжээний зөвлөмж (удирдах дээд байгууллага, хэрэгжүүлэгч, хамтрах, дэмжих байгууллагад, ахуйн нэгж байгууллага, хувь хүнд чиглэсэн)
- Хавсралт
- Үнэлгээнд ашигласан эх сурвалж

4.11.13.эрсдэлийн үнэлгээний тайланг цахим болон хэвлэмэл хэлбэрээр архивлаж хадгална.

4.12.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарч, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээнд ашиглах магадлал, үр дагаврын түвшин тогтоох дараах асуумжийг ашиглана (Маягт 1-4).

Маягт 1. Халдварт өвчний дэгдэлт, шинэ болон сэргэн тархаж буй халдварын тохиолдол, зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол, мал, гэрийн тэжээвэр амьтны халдварт өвчний тохиолдол, зүй бус хорогдол, зэрлэг амьтны зүй бус хорогдол, хоол, хүнсний шалтгаант хордлогын үйл явдлын жишиг асуумж

	Асуулт	1-5 оноо
	Магадлалын түвшин тогтоох асуулт	
Тархах эрсдэл	Энэ үйл явдал өмнө нь бүртгэгдэж байсан уу?	
	Тохиолдлын тоо болон кластер нэмэгдэх хандлагатай байна уу?	
	Тухайн үйл явдлын нөхцөл байдал хүндрэх хандлагатай байна уу?	
	Болсон үйл явдал /халдвар/ цаашид даамжирч байна уу?	
	Тухайн орон нутгийн хил хязгаараас хальж бусад аймаг, орон нутагт халдвар тархах эрсдэлтэй юу?	
	Халдварлалтын түвшин өндөр үү?	
	Эх уурхай дамжуулагчаас үүсгэгч илэрсэн үү?	
	Байгалийн голомттой юу?	
	Зоонозын өвчний улиралчлал мөн үү?	
	Идэвхтэй тандалт судалгаа хийгдэж байна уу?	
	Хил залгаа улс орноос халдвар зөөвөрлөгдөн орж ирэх магадлалтай юу?	
	Үүсгэгч	Уг өвчний үүсгэгч шинэ үү?
Уг өвчний үүсгэгч вирус мутацлагдах эрсдэлтэй юу?		
Үүсгэгчийн хоруу чанар өндөр үү?		
Эх уурхай	Хилийн нэвтрэх цэгээр халдвар зөөвөрлөгдөн орж магадлалтай юу?	
	Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын тоог тогтооход хүндрэлтэй юу?	
	Батлагдсан тохиолдлын хоёрдогч хавьтлын тоог тогтооход хүндрэлтэй юу?	
	Ойрын хавьтлыг бүрэн тодорхойлж, бүртгэх боломжтой юу?	
	Халдварын эх уурхай бүрэн тогтоогдсон уу?	
	Батлагдсан тохиолдлоос эмнэлзүйн шинж тэмдэггүй хэлбэр дийлэнх хувийг эзэлж байна уу?	
	Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл хийх боломжтой юу?	
	Мал, амьтанд илэрсэн эмнэлзүйн шинж тэмдэг ижил төстэй байна уу?	
Ижил шинж тэмдэгтэй өвчлөл бүртгэгдэж байна уу?		
	Үр дагаврын түвшин тогтоох	
НЭМ-ийн арга хэмжээ	Өвөрмөц урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж байгаа юу?	
	Зорилтот бүлгийн хүмүүсийн вакцинжуулалтын хамралт халдварын тархалтад нөлөөлөх түвшинд хүрсэн үү?	
	Вакцинд хамрагдаагүй бүлгийн /жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүд, хүүхэд/ хүн амд халдвараас сэргийлэх арга хэмжээ авч эхэлсэн үү?	
	Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр хаасан уу?	
	Аливаа үйл ажиллагаанд цагийн хязгаарлалт тогтоосон уу?	
	Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний чиглэл тодорхой байна уу?	
	Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?	
	Хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон уу?	
	Иргэд хөл хорио, халдвараас сэргийлэх дэглэм зөрчиж байна уу?	
	Олон нийтийн анхаарлыг татаж, түгшүүр төрүүлэх, эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлтэй юу?	
	Бүх ойрын хавьтлыг тусгаарлах боломж байна уу?	
	Ойрын хавьтлыг тусгаарлалтын хугацаанд шинжилгээнд бүрэн хамруулж чадаж байна уу?	
	Ойрын хавьтал болсон тухай мэдээллийг иргэдэд хүргэх боломж байна уу?	

	Хүн амын дунд болон эмнэлэгт суурилсан тандалтын идэвхтэй илрүүлэг хийж чадаж байна уу? Уг өвчин хүнд халдварлах эрсдэлтэй юу?	
Тусламж үйлчилгээ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээний бэлэн байдал хангагдсан уу?	
	Мал эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж хэр байна вэ?	
	Тухайн орон нутагт бх-ПГУ-ын шинжилгээ хийх боломжтой юу?	
	Вирусийн генотипын төрлийг тодорхойлох боломж бүрдсэн үү?	
	Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний хүртээмж хэр байна вэ?	
	Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын орны ачаалал нэмэгдсэн үү?	
	Хүндэвтэр болон хүнд өвчтний эзлэх хувь нэмэгдэж байна уу?	
	Нас баралтын түвшин өндөр байна уу?	
	Батлагдсан тохиолдлыг тусгаарлахад цаг алдаж байна уу?	
	Амьтны хоргодол их байна уу?	
Бэлэн байдлын нөөц	Хариу арга хэмжээний зардал өндөр үү?	
	Хариу арга хэмжээ авахад улс/орон нутгийн чадавх, нөөц хүрэлцээтэй юу?	
	Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл, нөөц шаардлагатай юу?	
	Лабораторийн шинжилгээний урвалж оношлуур /түргэвчилсэн болон ПГУ/-ын нөөц хүрэлцээтэй юу?	
	Эрүүл мэндийн салбарын сургагдсан хүний нөөц хүрэлцээтэй юу?	
	Вакцины нөөц байна уу?	
	Эмнэлгийн тусламж үйлчилгээний түвшин бүрт хавьтлын судалгаа хийх чадавхтай юу?	
	Сэжигтэй тохиолдол бүрт шинжилгээ хийх боломж байна уу?	
Батлагдсан тохиолдол бүрийг эмнэлэгт бүрэн тусгаарлан эмчлэх боломжтой юу?		

Маягт 2. Агаар, ус, хөрсний аюулгүй байдлын үзүүлэлтийн өөрчлөлт, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын алдагдал, хортон шавж, мэрэгчийн тархалтын үйл явдалтай холбоотой жишиг асуумж

	Асуулт	1-5 оноо
Магадлалын түвшин тогтоох асуулт		
Тархах эрсдэл	Энэ үйл явдал өмнө нь бүртгэгдэж байсан уу?	
	Тухайн үйл явдлын нөхцөл байдал хүндрэх хандлагатай юу?	
	Болсон үйл явдал /халдвар/ цаашид даамжирч байна уу?	
	Тухайн үйл явдал газар нутгаа тэлэх эрсдэлтэй юу?	
	Агаарын чанарын индексийн үзүүлэлт "аюултай" түвшинг заагаад 24 цагаас хэтэрсэн үү?	
	Усны аюулгүй байдлын аль үзүүлэлт босго хэмжээнээс давсан бэ?	
Өртөлт	Хөрсний аюулгүй байдлын аль үзүүлэлт босго хэмжээнээс давсан бэ?	
	Үйл явдал тархсаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үү?	
	Байгаль орчинд сэргэшгүй өөрчлөлт оруулах уу?	
	Ундны усыг бохирдуулсан уу?	
	Уг үйл явдал суурин газарт болсон уу?	
	Үйл явдлын улмаас өртөх эрсдэлтэй хүн амын эмзэг байдал нэмэгдэх үү?	
Үр дагаврын түвшин тогтоох асуулт		
НЭМ-ийн арга хэмжээ	Идэвхтэй тандалт судалгаа хийгдэж байна уу?	
	Бүх шатны анхан шатны эрүүл мэндийн байгууллага хариу арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой юу?	
	Бүх шатны мал эмнэлгийн байгууллагад тусламж үйлчилгээний бэлэн байдал хангагдсан уу?	
	Хүн амд сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах төлөвлөгөө байгаа юу?	
	Тухайн орон нутагт шинжилгээ хийж, шалтгаан тогтоох боломжтой юу?	
	Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?	
	Хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон уу?	
	Хүн амыг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх боломж байгаа эсэх?	
	Иргэд хөл хорио, халдвараас сэргийлэх дэглэм зөрчих эрсдэл байна уу?	

Хохирол	Олон нийтийн анхаарлыг татаж, түгшүүр төрүүлэх, эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлтэй юу?	
	Аюулгүйн үзүүлэлт нэмэгдсэнээр хүний эрүүл мэндэд хурц нөлөөлөх эрсдэл хэр вэ?	
	Олныг хамарсан хүн өвдөх эрсдэлтэй юу?	
	Тухайн үйл явдалтай холбоотой нас баралт гарсан уу?	
Бэлэн байдал	Агаар, хөрс, усны бохирдолтой холбоотой амьсгал, зүрх судас, гэдэсний халдварт өвчний дуудлагын тоо нэмэгдсэн үү?	
	Өртсөн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал хангагдсан уу?	
	Эм, антидот хангалттай байна уу?	
	Хариу арга хэмжээний зардал өндөр үү?	
	Хариу арга хэмжээ авахад улс/орон нутгийн чадавх, нөөц хүрэлцээтэй юу?	
	Эсрэг асуух уу	
	Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл, нөөц шаардлагатай юу?	
	Сургагдсан хүний нөөц хүрэлцээтэй юу?	
Бохирдуулагчийн шинж чанарыг тодорхойлж илрүүлэх лаборатори байгаа юу?		
Хортон шавж, мэрэгчийн төрөл зүйл, хор хөнөөлийг тогтоох чадавх бий юу?		

Маягт 3. Цацрагийн осол хордлого, химийн бодисын алдагдал, осол, хордлогын үйл явдалтай холбоотой жишиг асуумж

Асуулт		1-5 оноо
Магадлалын түвшин тогтоох асуулт		
Тархах эрсдэл	Энэ үйл явдал өмнө нь бүртгэгдэж байсан уу?	
	Тохиолдлын тоо болон голомт нэмэгдэх хандлагатай байна уу?	
	Тухайн үйл явдлын нөхцөл байдал хүндрэх хандлагатай юу?	
	Болсон үйл явдал /халдвар/ цаашид даамжирч байна уу?	
	Идэвхтэй тандалт судалгаа хийгдэж байна уу?	
Үүсгэгч	Өртсөн хүний тоо тодорхой юу?	
	Ямар төрлийн химийн бодис гэдгийг тогтоосон уу?	
	Химийн бодисын үндсэн шинж чанар нь илүү эрсдэлтэй юу?	
	Эх үүсвэрийг тогтоосон уу?	
Өртөлт	Байгаль орчноос бүрэн арилах уу?	
	Хими, цацрагийн нөлөө нь хүн, мал, амьтанд үзүүлэх нөлөө нь аюултай юу?	
	Тухайн газар нутагт сууршлын бүсэд байрласан уу?	
	Эргэн тойронд олон хүн өртөх эрсдэлтэй юу?	
НЭМ-ийн арга хэмжээ	Ундны усны эх булагт ойр байрладаг уу?	
	Бүх шатны байгууллага хариу арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой юу?	
	Үр дагаврын түвшин тогтоох асуулт	
	Олон нийтийн анхаарлыг татаж, түгшүүр төрүүлэх, эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлтэй юу?	
	Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?	
	Ус, хөрс, гадаад орчинд удаан хадгалагдах боломжтой юу?	
	Бүх шатны анхан шатны эрүүл мэндийн байгууллага хариу арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой юу?	
	Хүн амд сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах төлөвлөгөө байгаа юу?	
	Тухайн орон нутагт шинжилгээ хийж, шалтгаан тогтоох боломжтой юу?	
	Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?	
	Хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон уу?	
	Хүн амыг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх боломж байгаа юу?	
Бэлэн байдал	Иргэд хөл хорио, халдвараас сэргийлэх дэглэм зөрчих эрсдэл байна уу?	
	Тухайн орон нутагт шинжилгээ хийж, шалтгаан тогтоох боломжтой юу?	
	Саармагжуулагч хангалттай мэдээлэл байна уу?	
	Хариу арга хэмжээний зардал өндөр үү?	
	Хариу арга хэмжээ авахад улс/орон нутгийн чадавх, нөөц хүрэлцээтэй юу?	

Хохирол	Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл, нөөц шаардлагатай юу?	
	Сургагдсан хүний нөөц хүрэлцээтэй юу?	
	Олон хүн хаматрч эрүүл мэндээрээ хохирох эрсдэлтэй юу?	
	Тухайн үйл явдалтай холбоотой нас баралт гарсан уу?	
	Хими, цацрагийн осол, алдагдалтай холбоотой өвчин, осол гэмтэл, нас баралтын тоо нэмэгдсэн үү?	
	Хөдөлмөрийн чадвар алдалт, хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо нэмэгдэх үү?	

Маягт 4. Байгалийн аюулт үзэгдлийн улмаас үүссэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үйл явдалтай холбоотой жишиг асуумж

Асуулт		1-5 оноо
Магадлалын түвшин тогтоох асуулт		
Тархалт	Энэ үйл явдал өмнө нь бүртгэгдэж байсан уу?	
	Тохиолдлын тоо нэмэгдэх хандлага байна уу?	
	Тухайн үйл явдлын нөхцөл байдал хүндрэх хандлагатай юу?	
	Төв суурин газраас хэр хол зайтай вэ?	
	Тухайн газар нутаг байршлын хувьд онцлогтой эсэх?	
	Тухайн газар нутагт өмнө нь ган, зудын нөхцөл байдал тохиолдож байсан уу?	
Өртөлт	Харилцаа, холбоо хэвийн явагдах боломжтой юу?	
	Нэрвэгдсэн иргэдэд хүрч үйлчлэхэд хүндрэлтэй юу?	
	Өртсөн хүний тоо хэд вэ?	
	Нас барсан хүний тоо, нас баралтын түвшин өндөр үү?	
	Хүн ам хэр нягтарсан бүс нутаг вэ?	
Эх үүсвэр	Гамшгийн улмаас учирсан хохирол хэр вэ?	
	Эх үүсвэрийг тогтоох боломжтой юу?	
	Гамшгийн эрсдэлийг богино хугацаанд таслан зогсоох боломжтой эсэх Хүний үйл ажиллагаатай холбоотой юу?	
Үр дагаврын түвшин тогтоох асуулт		
Хариу арга хэмжээ	Олон нийтийн анхаарлыг татаж, түгшүүр төрүүлэх, эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлтэй юу?	
	Эмзэг бүлгийн хүн амыг тогтоож нүүлгэн шилжүүлэх боломжтой юу?	
	Хорогдсон малын төрөл, тоо	
	Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?	
Бэлэн байдал	Тухайн үйл явдалтай холбоотой нас баралт гарсан уу?	
	Эмзэг бүлгийн иргэдэд тусламж үзүүлэх боломж байгаа юу?	
	Бүх шатны мэргэжлийн байгууллага хариу арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой юу?	
	Хариу арга хэмжээний зардал өндөр үү?	
	Хариу арга хэмжээ авахад улс/орон нутгийн чадавх, нөөц хүрэлцээтэй юу?	
	Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл, нөөц шаардлагатай юу? Дайчлагдан ажиллах хүний нөөц хүрэлцээтэй юу?	

4.13. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний дүнд үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эрсдэлийн түвшин	Идэвх -жилийн зэрэг	Хариу арга хэмжээний чиглэл	
		Үндэсний түвшинд эрсдэлийг үнэлсэн тохиолдолд	Орон нутгийн түвшинд эрсдэлийг үнэлсэн тохиолдолд
Маш бага	0	- Үйл явдлыг хаах; - Холбогдох тушаал, зааврын дагуу тайван цагийн горимоор ажиллах;	- Үйл явдлыг хаах; - Холбогдох тушаал, зааврын дагуу тайван цагийн горимоор ажиллах;
Бага	0	- Үйл явдлыг үргэлжлүүлэн ажиглах; - Холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллах;	- Үйл явдлыг үргэлжлүүлэн ажиглах; - Холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллах;

		<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай бол хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагад мэдээллийг хүргүүлэх; 	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай бол хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагад мэдээллийг хүргүүлэх;
Дунд	I	<ul style="list-style-type: none"> - Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагад мэдээллийг хүргүүлэх; - Төрийн захиргааны төв байгууллага, Улсын онцгой комисс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Олон улсын эрүүл мэндийн дүрмийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага (ӨХСҮТ)-д мэдээлэх; 	<ul style="list-style-type: none"> - Аймаг/нийслэлийн тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагад мэдээллийг хүргүүлэх; - Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллага, Олон улсын эрүүл мэндийн дүрмийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага (ӨХСҮТ)-д мэдээлэх;
Өндөр	II	<ul style="list-style-type: none"> - Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Олон улсын эрүүл мэндийн дүрмийн үндэсний зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Харьяа төрийн захиргааны төв байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудад мэдээллийг хүргүүлэх; - Төрийн захиргааны төв байгууллага, Улсын онцгой комисс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлэх; 	<ul style="list-style-type: none"> - Аймаг/нийслэлийн тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Тухайн орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд идэвхжилийн горимд шилжиж, тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах; - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудад мэдээллийг хүргүүлэх; - Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллага, Олон улсын эрүүл мэндийн дүрмийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага (ӨХСҮТ)-д мэдээлэх;
Маш өндөр	III	<ul style="list-style-type: none"> - Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Олон улсын эрүүл мэндийн дүрмийн үндэсний зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Харьяа төрийн захиргааны төв байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Улсын онцгой комиссын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; 	<ul style="list-style-type: none"> - Аймаг/нийслэлийн тэргүүлэх чиглэлийн байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Тухайн орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд идэвхжилийн горимд шилжиж, тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах; - Аймаг/нийслэлийн онцгой комиссын тохиолдлын удирдлагын тогтолцоо идэвхжих; - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх;

		<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх; - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудад мэдээллийг хүргүүлэх; - Төрийн захиргааны төв байгууллага, Улсын онцгой комисс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлэх; - Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас дэмжлэг хүсэх тухай хэлэлцэх; 	<ul style="list-style-type: none"> - Хамтрах, дэмжлэг үзүүлэх байгууллагуудад мэдээллийг хүргүүлэх; - Харьяа төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний тэргүүлэх чиглэлийн байгууллага, Олон улсын эрүүл мэндийн дүрмийн зохицуулагч үндэсний эрх бүхий байгууллага (ӨХСҮТ)-д мэдээлэх;
--	--	--	---

Тав. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах

5.1. Ерөнхий зохицуулалт

5.1.1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд нь Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын Шуурхай удирдлагын төв (цаашид “Шуурхай удирдлагын төв” гэх)-тэй байна.

5.1.2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, түүнд хүргэж болзошгүй үйл явдал бүртгэгдсэн үед эрсдэлийн түвшин, идэвхжилийн зэргээс хамаарч тохиолдлын удирдлагын тогтолцооны зарчмаар ажиллана.

5.1.3.Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллахдаа Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005), холбогдох эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

5.1.4.Тайван цагт эрсдэлийн үнэлгээ хийх, тохиолдлын удирдлагын тогтолцооны бэлэн байдлыг хангах зорилгоор дасгал сургууллт, сургалтыг холбогдох салбар бүр зохион байгуулна.

5.2. Шуурхай удирдлагын төвийн үндсэн чиг үүрэг

5.2.1.төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд нь тохиолдлын удирдлагын тогтолцооны баг, бүрэлдэхүүн байрлан хэвийн үйл ажиллагаа явуулах дэд бүтэц, аюулгүй байдлыг хангасан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн Шуурхай удирдлагын төв (ШУТ)-тэй байна.

5.2.2.ШУТ нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмж, аюулгүй байдал бүрэн хангагдсан зориулалтын байртай байх;
- Сургагдсан, чадварлаг хүний нөөцтэй байх;
- Үйл ажиллагаа явуулах эрхзүйн бичиг баримт, төлөвлөгөө, стандарт үйл ажиллагааны заавартай байх;
- Программ хангамж ба өгөгдөл, мэдээллийн сантай байх;

5.2.3.ШУТ нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Олон эх сурвалжит тандалт хийх;
- Үйл явдлын мэдээллийг тогтмол солилцох;
- Мэдээлэл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэл бэлтгэх, түгээх;

- Шийдвэр гаргагчдыг холбогдох шуурхай мэдээллээр хангах;
- ТУТ-ны бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах;
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдал бүртгэгдсэн тохиолдолд эрсдэлийн түргэвчилсэн болон нөхцөл байдлын үнэлгээг зохион байгуулах;
- ТУТ идэвхжсэн үед дэмжлэг үзүүлэх;
- Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, зохицуулах, тайван цагт мэдээлэл солилцох.

5.2.4. ШУТ нь дараах үйл ажиллагааны горимтой байна.

- Ажиглалтын горим: үндсэн үйл ажиллагааг өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны горимд гүйцэтгэх;
- Анхааруулах горим: бүртгэгдсэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын явцыг эрчимтэй хянах, идэвхжилийн зэрэгт шилжихэд бэлтгэх;
- Ажиллагааны горим: бүртгэгдсэн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын хариу арга хэмжээг идэвхтэй удирдан зохион байгуулах.

5.2.5. ажиглалтын горимд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ШУТ-ийн үндсэн ажилтан чиг үүргийн дагуу ажиллах;
- Мэдээ, мэдээллийг олон эх сурвалжаас цуглуулах, нэгтгэх, мэдээллийн сан үүсгэх;
- Мэдээ, мэдээлэлд тогтмол дүн шинжилгээ хийх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй үйл явдлын мэдээлэл байгаа эсэхийг тодорхойлох;
- Эргэн мэдээлэл бэлтгэж, холбогдох байгууллага, удирдлага, мэргэжилтнүүдэд хүргүүлэх;
- Үйл явдалд суурилсан тандалт хийх;

5.2.6. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдал бүртгэгдсэн тохиолдолд анхааруулах горимд шилжиж дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Анхааруулах горимд шилжсэн ч ШУТ-ийн үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;
- ШУТ-ийн менежер нь ШУТ-ийн үйл ажиллагаа анхааруулах горимд шилжсэн тухай холбогдох дээд шатны болон хамтрах байгууллага, удирдлагад мэдэгдэх;
- ШУТ-ийн үндсэн ажилтнаас гадна шаардлагатай бол тухайн чиглэлээр дадлага, туршлагатай мэргэжилтэн, шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийг нэмэлтээр дуудаж ажиллуулах;
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын тандалтыг өргөтгөж, эрчимжүүлэх;
- Богино хугацаанд хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх;
- Хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулахад бэлтгэх;
- Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх.

5.2.7.эрсдэл “Дунд” болон түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн тохиолдолд “Ажиллагааны горим”-д шилжиж дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ШУТ-ийн менежер нь ШУТ-ийн үйл ажиллагаа анхааруулах горимд шилжсэн тухай холбогдох дээд шатны болон хамтрах байгууллага, удирдлагад мэдэгдэх;
- Шаардлагатай бол урьдчилан бэлтгэсэн мэргэжилтнүүдийг дайчлан ажиллуулах;
- ТУТ-г идэвхжүүлэх, үйл явдлын төрлөөс хамаарч бие бүрэлдэхүүнийг томилох эсхүл урьдчилан томилсон багийг ажиллуулах;
- Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- ТУТ-ны багийг эрсдэлийн түвшин, үйл явдлын төрөл, цар хүрээтэй уялдуулж урьдчилсан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу идэвхжүүлэх;
- Хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх;
- Шаардлагатай бол нөөцийг хуваарилж, шуурхай хүргүүлэх;
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын талаар нөхцөл байдлын мэдээ бэлтгэн, хамтрах, дэмжих байгууллага, удирдлагуудад хүргүүлэх;
- Эрсдэлийн нөхцөл байдлын давтан үнэлгээгээр эрсдэл “маш бага” эсхүл “бага” түвшинд үнэлэгдсэн тохиолдолд ажиглалтын горимд шилжиж хэвийн ажиллах, холбогдох албан тушаалтанд мэдээлэх;

5.2.8.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдал бүрийн дараа хариу арга хэмжээний дараах үнэлгээг хийж, илэрсэн сургамж, цаашид анхаарах асуудал, зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, дараагийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.

5.3.Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг

5.3.1. ТУТ нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үйл явдлын үед төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлагын тогтолцооны хүрээнд уялдуулан зохицуулж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллана.

5.3.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг урьдчилан томилж, баталгаажуулсан байна.

5.3.3. ТУТ нь дараах шаардлагад нийцсэн байна.

- шаталсан удирдлагын тогтолцоотой байх;
- нэгдсэн бүтэц, нийтлэг загвартай байх;
- бие бүрэлдэхүүний хувьд эрсдэлийн түвшинд тохирсон бүтэцтэйгээр ажиллах;
- нөхцөл байдлын өөрчлөлтөд мэдрэг, уян хатан байх.


5.3.4.ТУТ-ны бие бүрэлдэхүүнд ажиллах мэргэжилтнийг гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд нь сургаж бэлтгэнэ. Тайван цагт ажиллах ШУТ-ийн менежер нь чиг үүргийн хувьд томилогдсон албан тушаалтан байна.

5.3.5.Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн ТУТ-ны горимоор ажиллах бөгөөд дараах бүтэц, бүрэлдэхүүн (бүдүүвч 1)-тэй байх ба нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, түүнд хүргэж болзошгүй үйл явдлын төрөл, эрсдэлийн түвшнээс хамааран багуудыг үе шаттайгаар идэвхжүүлж ажиллана. Үйл явдлын төрөл болон орон нутгийн онцлогт тохируулан багийн бүрэлдэхүүнд зохицуулалт хийж болно.

5.3.6.ТУТ-ны бие бүрэлдэхүүн нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- зохицуулагч
- дэд зохицуулагч
 - аюулгүй байдлын ажилтан
 - холбогч
- үйл ажиллагааны баг
- төлөвлөлтийн баг
- санхүү, нөөцийн удирдлагын баг
- захиргааны удирдлагын баг
- эрсдэлийн харилцаа, холбооны баг

Бүдүүвч 1. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүн



5.3.7.Зохицуулагчийн үндсэн чиг үүрэг:

- Тохиолдлын удирдлагын тогтолцооны зохицуулагч нь үндэсний түвшинд яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн тухайн асуудал хариуцсан нэгж (газар)-ийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан, бусад байгууллагын хувьд байгууллагын дарга, захирал байна.
 - Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг хянах, баталгаажуулах, нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох;
 - Хариу арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах;
 - Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг шуурхай асуудлаар хуралдуулах, шийдвэрийг баталгаажуулах;
 - Хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэхтэй холбоотой салбар хоорондын байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
 - Салбарын сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Улсын онцгой комиссыг мэдээллээр хангаж ажиллах;

- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүнийг эрсдэлийн түвшинд тохируулан өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах;
- Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх, шийдвэрийг цуцлах, хариу арга хэмжээний удирдлагыг мэргэжлийн төв байгууллагад шилжүүлэх зэрэг шийдвэр гаргах;
- Хариу арга хэмжээнд шаардлагатай зардлын төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих;
- Үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаарх мэдэгдлийг олон нийтэд хүргэх;
- Мэдээллийн үнэн бодит байдал, сургалт сурталчилгааны материалын агуулгыг хянах;
- Дэд зохицуулагч, холбогч, аюулгүй байдал хариуцсан ажилтныг шууд удирдлагаар хангах;
- Хариу арга хэмжээний явцын болон нэгдсэн тайланг хянаж, баталгаажуулах;

5.3.8. Дэд зохицуулагчийн үндсэн чиг үүрэг:

- Дэд зохицуулагч нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарч чиг үүргийн хувьд шууд хариуцах албан тушаалтан байна.
- Зохицуулагчийн эзгүйд түүний чиг үүргийг шууд орлон гүйцэтгэх;
- Багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн, Зохицуулагчид тайлагнах, зохих шийдвэрийг гаргуулах;
- Үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээний явц үр дүнгийн талаарх албан ёсны мэдэгдлийг хянах;
- Өдөр тутмын шуурхай хуралдааныг зохион байгуулах, хэлэлцэх мэдээллийг хянах;
- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний үндсэн ажлыг зохицуулах;
- Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын өдөр тутмын үйл ажиллагааг тодорхойлох, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
- Шинээр дайчлагдсан ажилтнуудад хийх ажлын чиглэл, удирдамжийг танилцуулах;
- Эрсдэлийн үеийн харилцаа холбооны бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянан баталгаажуулах;

5.3.9. Аюулгүй байдал хариуцсан бүлэг/ажилтны үндсэн чиг үүрэг:

- Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;
- Бие бүрэлдэхүүний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, зохицуулагчид мэдэгдэн, шийдвэрлүүлэх;
- Бие бүрэлдэхүүнийг ажлын бус цагаар хүргэх, авах үйлчилгээг зохион байгуулах;
- Бие бүрэлдэхүүний ажлын ачааллыг тооцоолж, түүнд үндэслэн ажлын цаг, амралтын зохицуулалт хийх саналыг гаргаж, шийдвэрлүүлэх;
- Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон хүнсний аюулгүй байдалд хяналт тавих;
- Бие бүрэлдэхүүний эрүүл мэндэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.

5.3.10. Холбогчийн үндсэн чиг үүрэг:

- ТУТ-г идэвхжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд бие бүрэлдэхүүнийг зарлан мэдээлэх дохиогоор цуглуулах;
- Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх явцад зохицуулагчийн шийдвэрээр нэмэлтээр дуудах шаардлагатай бие бүрэлдэхүүнийг зарлан дуудах;
- ТУТ-ын хурлын шийдвэрийг багуудад шуурхай хүргэж, гүйцэтгэлд хяналт тавин, хэрэгжилтийг удирдлагад танилцуулах;
- Бусад салбарын болон олон улсын байгууллагаас шаардлагатай мэдээллийг солилцоход багуудад дэмжлэг үзүүлэх;
- Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага, бусад салбарын мэргэжилтнүүд нь холбогчоор ажиллах үедээ шаардлагатай үед үндсэн байгууллага баталгаат мэдээ, мэдээллээр хангах;

5.3.11.Төлөвлөлтийн багийн үндсэн чиг үүрэг:

- Төлөвлөлт болон эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бусад багуудаас авах;
- Эрсдэлийн үнэлгээг удирдан зохион байгуулах, өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээлэлд үндэслэн шаардлагатай тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, дэд зохицуулагч, зохицуулагчид танилцуулах;
- Үнэлгээний дүнд үндэслэн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, шаардлагатай тохиолдолд шуурхай тодотгол хийх;
- Үүссэн нөхцөл байдалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, хэтийн төлвийг тооцоолох;
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болох үйл явдалд тархвар зүйн дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээний чиглэл бодлого гаргахад ашиглах;
- Үйл явдлын цар хүрээнээс хамаарч шаардагдах нөөц (хүний нөөц, эм, урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл г.м)-ийг тооцоолж төлөвлөх;
- Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянах, явцын болон дараах үнэлгээ хийх;
- Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, журам, түр заавар, албан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах, батлуулах;
- Багийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл бусад эд зүйлсийн хүсэлтийг нөөцийн багт тавьж шийдвэрлүүлэх;

5.3.12.Үйл ажиллагааны багийн үндсэн чиг үүрэг:

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах;
- Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай бодлогын баримт бичгийг хамтран боловсруулах, хянах;
- Төлөвлөлтийн багаас боловсруулсан хариу арга хэмжээний
- Төлөвлөгөөний өдөр тутам хэрэгжилтийг зохион байгуулах;
- Мэргэжлийн төв байгууллагаас томилогдон ажиллаж буй шуурхай хариу арга хэмжээний багуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тархвар зүйн тандалт, хавьтлын судалгаа хийх;

5.3.13. Санхүү, нөөцийн удирдлагын багийн үндсэн чиг үүрэг:

- Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, хяналт тавих;

- Бүх төрлийн нөөцийн мэдээллийг цуглуулах, шинэчлэх, бусад баг болон удирдлагыг мэдээллээр хангах;

- Хариу арга хэмжээнд шаардагдах зардлын тооцооллыг хийж, санал боловсруулж шийдвэрлүүлэх;

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын улмаас нөхөн олговор олгох шаардлагатай бол тооцоо хийж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

- Хариу арга хэмжээнд шаардлагатай худалдан авалтын гэрээ хийх, худалдан авалтын ажлыг зохион байгуулах;

- Шаардлагатай тохиолдолд халдварт өвчний болон гамшгийн нөөцийг дайчлах, шилжүүлэх санал боловсруулж шийдвэрлүүлэх;

- ТУТ-ны бие бүрэлдэхүүний болон хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөцийг дайчлан ажиллуулах ажлын цагийн хуваарь боловсруулан батлуулах;

5.3.14. Захиргааны удирдлагын багийн үндсэн чиг үүрэг:

- Багуудын болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн тооцоог бүртгэх, цалинг тооцож олгох;

- Багуудаас гарч байгаа албан бичгийн боловсруулалтад хяналт тавих;

- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, стандартын хэрэгжилтийг хангах;

- ТУТ-ны багуудын өдөр тутмын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны илтгэх хуудас, тайланг авч нэгтгэх, удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангах;

- Бие бүрэлдэхүүнийг ажлын байр, техник тоног төхөөрөмж, дэд бүтэц хоол, хүнсээр хангах асуудлыг шийдвэрлэх;

- Шаардлагатай бичиг баримтыг хувилан олшруулах, тараах, устгах, баримтжуулах, архивлах үйл ажиллагааг гүйцэтгэх;

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар багуудын тавьсан саналыг шийдвэрлэх;

5.3.15. Эрсдэлийн харилцаа, холбооны багийн үндсэн чиг үүрэг:

- Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан олон нийтэд хийх анхны мэдээллийн төслийг боловсруулж, мэдээлэл хийх;

- Өдөр тутмын үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг бэлтгэх;

- Зорилтот бүлгийн хүн амыг тогтоох, мэдээллийн хэрэгцээг нь тодорхойлж, хүргэх;

- Байгууллагын цахим хуудас нийгмийн сүлжээгээр дамжуулан хүн амыг мэдээллээр тасралтгүй хангах;

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах;

- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх хуваарь гарган батлуулж, хэрэгжүүлэх;

- Хэвлэлийн бага хурал (идэвхжилийн, явцын, цуцалсны дараах)-ыг зохион байгуулах;

- Хүн амд чиглэсэн сэрэмжлүүлэг, санамж, зөвлөмж, мэдээлэл, сургалт сурталчилгааны материалын эхийг бэлтгэх, түгээх;

- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн харилцааны сүлжээгээр цацагдаж байгаа үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг шүүх, хариу мэдэгдэл хийх шаардлагатай мэдээллийг менежерт тайлагнах;

- Хариу арга хэмжээний сайн туршлага, манлайлан ажиллаж буй ажилтнууд болон эрсдэлийг даван туулсан хүмүүсийн түүх, туршлагыг бичиж, сурталчлах;

- Хариу арга хэмжээний үед ашигласан мэдээлэл, сургалт сурталчилгааны материалыг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах, архивлах;

5.3.16.Багуудын нийтлэг чиг үүрэг:

- Өдөр тутмын хэрэгжүүлсэн арга хэмжээний илтгэх хуудсыг Захиргаа санхүүгийн багт хүлээлгэн өгөх, удирдлагыг мэдээллээр хангах;

- Багийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл бусад эд зүйлсийн хүсэлтийг нөөцийн удирдлагын багт тавьж шийдвэрлүүлэх;

- Багийн болон дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг мөрдөн ажиллах заавар журмаар хангах, түргэвчилсэн сургалт зохион байгуулах;

- Багийн бие бүрэлдэхүүний ажлын цагийг зохицуулах, ажил амралтын зохицуулалтын саналыг Аюулгүй байдлын бүлэгт тавьж шийдвэрлүүлэх;

- Багууд хоорондоо мэдээллийг шуурхай солилцох;

- Удирдлагын үүрэг даалгавраар нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.3.17.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрлөөс үл хамаарч хариу арга хэмжээг цаг хугацааны дарааллаар дараах байдлаар зохион байгуулна (Хүснэгт 2).

5.3.18.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын цар хүрээ, өрнөлөөс хамааран нэмэлт арга хэмжээг зохион байгуулж болно.

Хүснэгт 2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээний зарчим, цаг хугацаагаар

Хэрэгжүүлэх хугацаа (цагаар)	Хэрэгжүүлэх түвшин		
	Орон нутаг	Мэргэжлийн төв байгууллага	Яам, агентлаг
Эхний 12 цагийн дотор	<ul style="list-style-type: none"> - Үйл явдлын төрлөөс хамаарч тэргүүлэх чиглэлийн байгууллагыг томилох; - Тэргүүлэх чиглэлийн байгууллага эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх; - Дээд шатны байгууллагад мэдээлэх; 	<ul style="list-style-type: none"> - Үндэсний түвшний байгууллагын хариуцах ажилтныг томилох; - Дэмжих багийг бүрдүүлэх; - Орон нутгаас хүсэлт ирсэн тохиолдолд холбогдох салбарын ажилтныг нэмэлтээр багт оруулж томилох; 	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл хүлээн авч удирдлага зохицуулалтаар хангах; - Эрсдэлийн харилцаа холбооны баг идэвхжих

	- Хариу арга хэмжээний салбар хоорондын багийг томилох;	- Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх; - Эрсдэлийн харилцаа холбооны баг идэвхжих	
48 цагийн дотор	- Салбар хоорондын хамтарсан эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх; - Хариу арга хэмжээг эрчимжүүлэн хамтарсан төлөвлөгөө гаргах; - Шаардлагатай нөөц бүрдүүлэх	- Эрсдэлийн түвшингээс хамаарч идэвхжилийн горимд шилжих; - Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангаж холбогдох арга хэмжээг авах; - Шуурхай хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулах; - Эрсдэлийн харилцаа холбооны баг идэвхжих;	- Мэргэжлийн төв байгууллагаас ирүүлсэн хүсэлт, саналыг шийдвэрлэх; - Төрөлжсөн мэргэшлийн тусламж үзүүлэх баг томилох; - Шаардлагатай тохиолдолд салбар дундын хамтарсан шуурхай хариу арга хэмжээний баг байгуулах; - Эрсдэлийн харилцаа холбооны баг идэвхжих
72 цагийн дотор	- Шуурхай хариу арга хэмжээг эрчимжүүлэх; - Холбогдох байгууллагуудтай хамтран хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	- Шуурхай хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;	- Дэмжлэг үзүүлэх; - Эрсдэлийн харилцаа холбооны баг идэвхжих
72 цагаас хойш	- Эрсдэлийн үнэлгээний дүнгээс хамаарч, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	- Эрсдэлийн түвшингээс хамаарч хариу арга хэмжээг хэрэгжүүлэх; - Явцын хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;	- Эрсдэлийн түвшингээс хамаарч хариу арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангах; - Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллах;
Идэвхжилийн зэргийг бууруулсан үед	- Үйл явдлыг дуусгавар болгон хариу арга хэмжээний тайлан гаргах; - Сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавих	- Үйл явдлыг дуусгавар болгон хариу арга хэмжээний нэгдсэн тайлан гаргах; - Төгсгөлийн үнэлгээ хийж зөвлөмж гаргах; - Сэргээн босгох үйл ажиллагаанд хяналт тавих;	- Хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх; - Сэргээн босгох үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

5.4. Эрсдэлийн харилцаа холбооны зохицуулалт

5.4.1. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд үнэн зөв, шуурхай мэдээлэл хүргэх, олон нийтийн оролцоог хангах, буруу ташаа мэдээлэл, цуу яриаг таслан зогсоох зорилгоор эрсдэлийн харилцаа холбоог үндэсний бүсийн болон орон нутгийн түвшинд зохион байгуулна.

5.4.2. эрсдэлийн харилцаа холбоог хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

- олон нийтэд үнэн зөв, ил тод, ойлгомжтой мэдээлэл хүргэж итгэлцлийг бий болгох;

- болзошгүй болон үүссэн эрсдэлийн талаар мэдээллийг эрт, шуурхай, үнэн зөв зарлан мэдээлэх;

- эрсдэлийн үнэлгээ, шийдвэр гаргалт болон хэрэгжүүлж буй арга хэмжээг ил тод мэдээлэх;

- хүн амын дундах ойлголт, хандлага, зан үйлийг тандан судалж, эрсдэлийн харилцаа холбоог зохион байгуулах;

- эрсдэлийн харилцаа холбооны үйл ажиллагааг урьдчилан төлөвлөж, бэлэн байдлыг хангах.

5.4.3. төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь эрсдэлийн харилцаа холбооны багтай байх бөгөөд багийн бүрэлдэхүүн, тухайн байгууллагын чиг үүрэг, орон нутгийн онцлогт нийцүүлэн багийг томилно. Багийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, боловсруулалт хариуцсан, хэвлэлийн төлөөлөгч, нийгмийн сүлжээ хариуцсан гишүүн, олон нийтийн төлөөлөл байна.

5.4.4. эрсдэлийн харилцаа холбооны үйл ажиллагааг тайван цагийн болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулна.

5.4.5. тайван цагийн үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Эрсдэлийн харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

- Болзошгүй нийгмийн эрүүл мэндийн эрсдэлд зориулсан сэргийлэх, хамгаалах мэдээллийн агуулгыг урьдчилан бэлтгэх;

- Хүн амын мэдээлэл авах сувгийг тодорхойлж, олон нийтийн оролцоог дэмжих;

- Эрсдэлийн харилцаа холбооны чиглэлээр багийн сургалт, дадлагажуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

5.4.6. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үүссэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Эрсдэлийн харилцаа холбооны багийг идэвхжүүлж, нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлэх;

- Үүссэн нөхцөл байдлын талаар анхны мэдээллийг шуурхай хүргэж, хүн амыг хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг олон нийтэд түгээх;

- Хүн амын дундах буруу ташаа мэдээлэл, цуу яриаг тандан илрүүлж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллээр тухай бүр залруулах;

- Зорилтот болон эмзэг бүлгийн хүн амд мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэх;

- Хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн асуулт, саналд тогтмол хариу өгөх.

Хүснэгт. Эрсдэлийн түвшинд тохирсон эрсдэлийн харилцаа холбооны арга хэмжээний чиглэл

Эрсдэлийн түвшин	Маш бага/Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
Үйл ажиллагаа	Тайван цагийн горимоор ажиллана.	- Үйл явдлын талаарх мэдээллийг 2 цагийн дотор хүн амд хүргэнэ. - Хүн амын дундах хандлагыг	- Нийгмийн эрүүл мэндийн үйл явдлын ноцтой байдлын мэдээллийг авмагц 2 цагийн	- Нийгмийн эрүүл мэндийн үйл явдлын ноцтой байдлын мэдээллийг авмагц 2 цагийн дотор олон нийтэд мэдээлнэ.

		<p>судалж, хариу арга хэмжээ авна.</p> <ul style="list-style-type: none"> - Үйл явдлаас хэрхэн сэргийлэх талаар мэдээллийг бүх сувгаар хүргэнэ. - Олон нийтэд хүргэх мэдээллийг эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, түгээнэ. - Зорилтот бүлгүүд, тэдний мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоож мэдээллийн төлөвлөгөөг гаргана. - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, цаашдын стратегийг боловсруулна. 	<p>дотор олон нийтэд мэдээлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Тогтсон цагт хэвлэлийн хурал хийнэ. - Үйл явдлын өрнөл, сэргийлэлт, өртөлт, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлнэ. - Эрсдэлийн мэдээлэл харилцааны нь эрсдэлийн түвшин нэмэгдэх үед дайчлах хүний нөөцтэй байх бөгөөд шинэчилсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. - Зохицуулагчийн шийдвэрээр эрсдэлийн мэдээлэл харилцааны салбар хоорондын багийг өртсөн бүс нутагт хүч нэмэгдүүлэн томилон ажиллуулна. - Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, татан оролцуулна. 	<ul style="list-style-type: none"> - Тогтсон цагт хэвлэлийн хурал хийнэ. - Үйл явдлын өрнөл, сэргийлэлт, өртөлт, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлнэ. - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг багийн бүх гишүүдэд өдөр тутам илгээнэ. - Иргэдийн дундах аман ярианд тогтмол тандалт хийнэ. - Дотоод, гадаадын түнш байгууллагуудад үйл явдлын мэдээллийг тогтмол бэлтгэн хүргүүлнэ. - Аюулд өртсөн иргэдийн тухай тогтмол мэдээлнэ. - Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, татан оролцуулна. - Нээлттэй утас ажиллуулна. - Хариу арга хэмжээ, хязгаарлалтын талаар мэдээлнэ. - Хэрэгжүүлж буй арга хэмжээний хугацаа, үр дагавар, сэргээн босголт, зардал, төсвийн талаар мэдээлнэ.
Анхны мэдээлэл өгөх албан тушаалтан	ЭХХ-ны баг	Холбогдох салбарын удирдах албан тушаалтан	Тухайн салбарын сайд, Төрийн нарийн бичгийн дарга	Ерөнхий сайд эсхүл Шадар сайд

5.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.5.1.энэхүү журмын хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жилд нэг удаа хийнэ.

5.5.2.Тэргүүлэх чиглэлийн байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд тусгаж, дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

- Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээ 90 буюу түүнээс дээш бол “бүрэн хангалттай” буюу шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн, үр дүнтэй хэрэгжиж байгаа, 60-89% бол “хангалттай” буюу шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, 59%-иас бага бол “хангалтгүй” буюу удирдлага зохион байгуулалт хангалтгүй гэж тооцно.

5.5.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр шалгуур үзүүлэлт “дунд” болон “хангалтгүй” үнэлгээ авсан бол хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллана.

5.5.4.Хяналт-шинжилгээний дүнд үндэслэн холбогдох нэгж, албан тушаалтанд зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулна.

Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
1.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарч, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 4 цагийн дотор хийж мэдээлсэн үйл явдлын эзлэх хувь	90-100%
2.	Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг 24 цагийн дотор хийсэн үйл явдлын эзлэх хувь	90-100%
3.	Хариу арга хэмжээг эрчимжүүлэн хамтарсан төлөвлөгөөг 48 цагийн дотор тодотгол хийсэн үйл явдлын эзлэх хувь	90-100%
4.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн талаарх хүн амд анхны мэдээлэл хүргэсэн хугацаа	2 цагийн дотор
5.	Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээнээс гарсан зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	90-100%
6.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарч эрсдэлийн үнэлгээний баг магадлалын болон үр дагаврын асуумжид нэмэлт хийж ашигласан үйл явдлын эзлэх хувь	70-100%
7.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дараа сэргээн босгох арга хэмжээ авсан үйл явдлын эзлэх хувь	90-100%
8.	Үйл явдлын дараа хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийсэн үйл явдлын эзлэх хувь	100%

Зургаа.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн зураглал гаргах аргачлал, эрсдэлийн зураглал

6.1. Ерөнхий зохицуулалт

6.1.1.Монгол Улсын хэмжээнд учирч болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн зураглал (цаашид “эрсдэлийн зураглал” гэх)-ыг үндэсний болон орон нутгийн түвшинд тодорхойлж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах “тэргүүлэх чиглэл” болгон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, төлөвлөлт хийхэд ашиглана.

6.1.2.эрсдэлийн зураглал гаргах аргачлалыг биологийн, нийгмийн, технологийн, байгалийн, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй болон гамшиг, осолтой холбоотой үйл явдлын үед эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус байгууллагууд ашиглаж болно.

6.1.3.Үндэсний болон орон нутгийн түвшний мэргэжлийн байгууллагууд хамтран энэхүү аргачлалыг ашиглаж, эрсдэлийн зураглалыг 2-3 жил тутамд шинэчилнэ (Үндэсний хэмжээний нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн матриц, зураглалыг Зураг 4, 5, 6-д харуулав).

6.1.4.Эрсдэлийн зураглал гаргахад ашигласан тоон мэдээ (эрсдэл үүсэх магадлал, хүндрэл, өртөмтгий байдал, даван туулах чадвар)-нд өөрчлөлт орох, эрсдэл үүсгэж болзошгүй нөхцөл байдал шинээр үүсэх болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээний дараа нөхцөл байдлын мэдээллийг


шинэчилж, эрсдэлийн зураглалыг дахин хийнэ.

6.2. Эрсдэлийн зураглал гаргах аргачлал

6.2.1. эрсдэлийн зураглалыг гаргахад оролцох мэргэжлийн байгууллагын албан тушаалтнууд зураглал гаргах аргачлалыг судалсан байна.

6.2.2. эрсдэлийн зураглалыг дор дурдсан алгоритмыг ашиглан 6 алхмаар хийнэ (Зураг 1).

Зураг 1. Эрсдэлийн зураглал гаргах алгоритм



АЛХАМ 1. Салбар хоорондын байгууллагын оролцоо шаардсан эрсдэлийг 4 дэд алхмаар тодорхойлно. Үүнд:

Дэд алхам 1.1. Салбар хоорондын байгууллагын оролцоо шаардсан эрсдэлийг жагсааж, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагавруудыг эрсдэл тус бүрээр тодорхойлно. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг дараах мэдээлэлд үндэслэн тогтооно. Үүнд:

- Өмнө нь хийгдэж байсан эрсдэлийн үнэлгээний дүн, тандалт судалгааны тайлан мэдээ, чадавхын үнэлгээний тайлан, статистикийн албан ёсны тоон мэдээ;
- Хөрш зэргэлдээ болон бусад улс орноос хил дамнан орж ирэх эрсдэлийн талаарх мэдээ;
- Өмнө нь тохиолдож байсан, салбар хоорондын хамтарсан хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан эрсдэл;

Дэд алхам 1.2. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг тодорхойлохдоо хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц эсхүл эрүүл мэндийн тогтолцооны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах бие махбодын, сэтгэлзүйн, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны сөрөг үр дагавруудыг оролцуулан тооцно. Сөрөг үр дагаврууд нь нийгмийн хүчин зүйл (хүйс, нийгэм эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээл гэх мэт)-д нөлөөлөх байдал, эрсдэлд өртсөн эмзэг бүлгийн хүн амд нөлөөлөх байдал, богино, дунд, урт хугацааны эрүүл мэндийн сөрөг үр дагаврыг оролцуулан тооцно. Тухайлбал: үерийн эрсдэлийн үед шууд гарах үр дагавар нь усанд живэх, гэмтэх, амьтанд хазуулах, сэтгэлзүйн гэмтэл авах, хоёрдогч үр дагавар нь усаар дамжих халдварт өвчин, үе хөлтнөөр дамжих халдварт өвчин, эрүүл мэндийн (эмнэлгийн барилга

байгууламж үерт автах, гэмтэх гэх мэт) тусламж үйлчилгээ доголдох, хүнсний аюулгүй байдал алдагдах гэх мэт.

Дэд алхам 1.3.Эрсдэлийг зураглан харж, эрсдэл бүрийн цар хүрээг тодорхойлно. Энэ алхмыг хийхэд газарзүйн байршил, эрсдэлт нөхцөл байдал үүссэн тохиолдолд шууд нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын байршил (хот, хөдөө, төвлөрсөн, тархмал, шилжин байршсан г.м)-ыг тодорхойлно.

Дэд алхам 1.4.Эрсдэлд өртөх магадлалтай хүний тоо, тэдгээрийн эрүүл мэндийн сөрөг үр дагаврыг тооцоолно. Үүнд:

- Газарзүй, ус цаг уур, нийгэм, техникийн эрсдэлийн хувьд тухайн эрсдэл өндөртэй бүс нутагт амьдарч буй хүний тоог тооцно.
- Халдварт өвчний хувьд тухайн өвчинд өртөмхий мэдрэг, халдварт өртөх магадлалтай хүний тоог тооцож гаргана.

АЛХАМ 2.Эрсдэлийн жагсаалт гаргасны дараа салбар хоорондын байгууллагын оролцоо шаардсан хамгийн өндөр эрсдэлийг одоогийн байгаа мэдээ, мэдээлэлд тулгуурлан 3 дэд алхмаар тодорхойлно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Магадлалыг үнэлэхэд цуглуулах мэдээлэл

Эрт сэрэмжлүүлэх болон тандалтын мэдээ, тайлан	Нэмэлтээр цуглуулах шаардлагатай тайлан, мэдээ (хэрэв боломжтой бол)
<ul style="list-style-type: none"> - Зайлшгүй бүртгэж мэдээлэх өвчний жагсаалт - Харуулдан тандалтын мэдээ - Өвчний статистик үзүүлэлт - Хам шинжийн тандалтын мэдээ - Нөөцийн мэдээ - Өвчлөлийн хандлага - Лабораторид суурилсан тандалт, чадавхын үнэлгээний тайлан мэдээ - Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд суурилсан тандалтын мэдээ - Нас баралтын бүртгэл, мэдээлэл - Идэвхтэй тандалтын мэдээ, тайлан 	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг тусгасан улсын хэмжээний газрын зураг - Хүн амын судалгаа (хоол тэжээлийн, дархлаажуулалтын, нас баралтын эргэмж судалгаа) - Нөөц, хариу арга хэмжээний төлөвлөгөө - Цартахал үүсгэх эрсдэлтэй томуу болон бусад халдварын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө (жишээ нь эбола, улаанбурхан, холер гэх мэт) - Өртөмтгий байдлын үнэлгээ, тайлан - Улсын даван туулах чадавхын үнэлгээний тайлан - Бусад холбогдох эрсдэлийн үнэлгээний тайлан - Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үеийн болон дараах үеийн үнэлгээний тайлан - Дасгал сургуулилтын тайлан - Эрүүл мэндийн ажилтны нөөц болон ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээтэй холбоотой бодлого, эрхзүйн баримт бичиг - Лабораторийн чадавхын үнэлгээний тайлан - Гишүүн улс орны үйл ажиллагааны жилийн тайлан (SPAR) - Хөндлөнгийн хамтарсан үнэлгээний тайлан - Нийгмийн бүлгийн судалгаа - Салбар хоорондын хамтарсан эрсдэлийн үнэлгээний тайлан - Зарим эрсдэлийн эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тайлан
<p>Бусад салбарын мэдээ, тайлан</p> <ul style="list-style-type: none"> - Бусад салбарт цуглуулагддаг эрүүл мэндтэй холбоотой мэдээ, мэдээлэл (жишээ: онгоцны буудал, хүнсний аюулгүй байдал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчин гэх мэт) - Хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээ - Хүмүүнлэгийн тусламж үйлчилгээ болон нүүлгэн шилжүүлэлт хийсэн тухай мэдээ - Цаг агаарын нөхцөл байдал, үер усны зураглал, геологийн тандалт судалгааны тайлан, мэдээ - Өртөмтгий бүлгийн хүн амын зураглал 	
<p>Статистикийн нээлттэй тоон мэдээ, дүн шинжилгээний тайлан</p> <ul style="list-style-type: none"> - Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын албан мэдээ - Олон улсын мэдээ, мэдээлэл солилцох нэгдсэн цахим систем (жишээ нь: Дэлхийн нийгмийн эрүүл мэндийн тандалтын сүлжээ, ProMED гэх мэт) - Эрсдэлийн удирдлага, зохицуулалтын INFORM индекс - Гамшгийн мэдээллийн сангийн систем (DesInventar) - Өгөгдөлд суурилсан урьдчилан таамаглах загварууд - Газарзүйн атлас - Их өгөгдлийн сан 	

Дэд алхам 2.1.Эрсдэлийн давтамжийг тодорхойлох буюу тодорхой хугацаанд салбар хоорондын байгууллагын оролцоо шаардсан эрсдэлийг тодорхойлохдоо тухайн нөхцөл байдал үүсэх магадлал дээр үндэслэн тооцно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Эрсдэлийн давтамжийн тодорхойлолт

Давтамж	Тодорхойлолт
Жил бүр	Жил бүр улирлын шинж чанартай
Богино хугацааны давтамжтай	1-2 жил тутамд
Удаан хугацааны давтамжтай	2-5 жил тутамд
Ховор	5-10 жил тутамд
Тодорхойгүй	Давтамжийг тодорхойлох боломжгүй

Дэд алхам 2.2.Эрсдэлийн улиралчлал нь жилийн аль улирал, сард тохиолдох өндөр магадлалтайг ногоон, шар, улбар шар, улаан өнгөөр гаргасан жилийн хуанли дээр тэмдэглэнэ (Зураг 5).

Дэд алхам 2.3.Эрсдэлийн улиралчлалыг тогтоосны дараа цуглуулсан мэдээ, мэдээлэл, оролцогчдын туршлага, үзэл бодол дээр тулгуурлан эрсдэл болох магадлалыг тодорхойлно (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Эрсдэл үүсгэх магадлалын тодорхойлолт

Түвшин	Магадлал	Тодорхойлолт
5	Маш өндөр магадлалтай	Алхам 1-т тодорхойлсон цар хүрээнд дараагийн 12 сард болох магадлал маш өндөр (95%-ийн магадлалтай)
4	Өндөр магадлалтай	Алхам 1-т тодорхойлсон цар хүрээнд дараагийн 12 сард болох магадлал өндөр (70%-94%-ийн магадлалтай)
3	Болзошгүй	Алхам 1-т тодорхойлсон цар хүрээнд дараагийн 12 сард тохиож болзошгүй (30%-69%-ийн магадлалтай)
2	Магадлал багатай	Алхам 1-т тодорхойлсон цар хүрээнд дараагийн 12 сард болох магадлал бага (5%-29%-ийн магадлалтай)
1	Маш бага магадлалтай	Алхам 1-т тодорхойлсон цар хүрээнд дараагийн 12 сард болох магадлал маш бага (5%-иас доош магадлалтай)


АЛХАМ 3.Тухайн эрсдэлийн нөлөөллийг тооцохдоо салбар хоорондын байгууллагын оролцоо шаардсан эрсдэлийн хувилбар дээр үндэслэн 4 дэд алхмаар тооцно. Нөлөөллийн үнэлгээг эрсдэлийн хүндрэлийн, өртөмтгий байдлын, даван туулах чадавхын гэсэн хүчин зүйл тус бүрээр хийх бөгөөд үнэлгээний дүнгийн нийлбэрээр тухайн эрсдэлийн нөлөөллийг тооцно.

Дэд алхам 3.1.Эрсдэлийн хүндрэлийн үнэлгээг хийхдээ 2 үндсэн алгоритмыг ашиглана (Зураг 2, 3).

Зураг 2. Биологийн эрсдэлийн хүндрэлийн үнэлгээний алгоритм



Зураг 3. Газарзүй, ус, цаг уур, техник, нийгмийн эрсдэлийн хүндрэлийн үнэлгээний алгоритм



Дэд алхам 3.2.Өртөмтгий байдал буюу тухайн эрсдэлийн хор уршигт өртөх хүн ам, эсхүл гамшгийн удирдлагын тогтолцоо, барилга байгууламжийн шинж чанар, нөхцөл байдлыг үнэлэхэд дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ (Хүснэгт 4).

- Эрсдэлд өртсөн хүн амын эрүүл мэндийн байдал (нас, хүйс, архаг хууч өвчин, хоол тэжээлийн дутагдал, дархлааны байдал гэх мэт)
- Нийгмийн тодорхойлогч хүчин зүйл (бичиг үсэг тайлагдсан байдал, ажилгүйдлийн түвшин, орон сууцанд амьдардаг өрхийн тоо, өрхийн орлого)
- Эмзэг бүлэг (орон гэргүй хүмүүс, нүүлгэн шилжүүлсэн хүмүүс, өндөр настан гэх мэт)

- Хүрээлэн буй орчны хүчин зүйлс (ундны ус болон хүнсний аюулгүй байдал алдагдах, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын менежмент, хүрээлэн буй орчны бохирдол, эрсдэл өндөртэй үйлдвэр, байгууламжийн ойролцоох хүн амын нягтрал, нийгэм, улс төрийн тогтворгүй байдал гэх мэт)

Хүснэгт 4. Өртөмтгий байдлын түвшин

Оноо	Өртөмтгий байдлын түвшин	Тодорхойлолт
5	Маш өндөр	Үнэлгээ хийх үед тодорхойлно.
4	Өндөр	
3	Дунд	
2	Бага	
1	Маш бага	

Дэд алхам 3.3. Аюулыг даван туулах чадавхыг үнэлэхдээ зайлшгүй байх ёстой чадавх бүрдсэн эсэх, тухайн чадавх нь аюулын үед хэр үр ашигтай ажиллаж байгааг тодорхойлох ба дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

Эрүүл мэндийн салбар:

- Эрт сэрэмжлүүлэх болон бусад тандалтын тогтолцоо, лабораторийн сүлжээ, тодорхой газарзүйн бүс нутагт үйл явдлын талаарх мэдээллийг эрт илрүүлэх, баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зэрэг мэдлэг, мэдээллийн менежмент;
- Өртсөн хүн амд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээний чадавх;
- Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн тасралтгүй байдлыг хангах чадавх;
- Эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдал, тасралтгүй сургах, хөгжүүлэх чадавх;
- Хариу арга хэмжээнд дайчлан ажиллуулах хүний нөөцийн чадавх.

Эрүүл мэндийн бус салбар:

- Нийгэм, хүрээлэн буй орчин, ус цаг уурын аюулыг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах тогтолцоо;
- Шийдвэр гаргахад ашиглагдах хүн амын шилжилт хөдөлгөөн, амьтны эрүүл мэндийн тандалтын мэдээ, агаарын нислэг болон цаг агаарын төлөв байдлын мэдээ зэрэг эрүүл мэндийн бус мэдээг цуглуулах, мэдээлэх тогтолцооны чадавх;
- Дайчлан ажиллуулах бэлэн байдлыг хангах, тасралтгүй сургах, хөгжүүлэх зэрэг хүний нөөцийн асуудлууд.

Эрх зүйн зохицуулалт:

- Бэлэн байдал, хариу арга хэмжээний үндэсний хэмжээний бодлого, стратеги, хууль, эрхзүйн баримт бичиг;
- Бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босголтын төлөвлөгөө;
- Салбарын хоорондын хамтран ажиллах механизм;
- Вакцин, эмнэл зүйн болон оношилгооны тусламж үйлчилгээ, бэлэн байдал, хариу арга хэмжээг сайжруулах, эрчимжүүлэхэд шаардлагатай эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, түүний зохицуулалтын тухай хууль тогтоомж;

- Шинэ халдварт өвчнийг зохицуулах хууль тогтоомж.

Олон нийтийн мэдлэгийн түвшин:

- Өртөмтгий бүлгийн мэдлэг, хандлага, дадал;
- Эрсдэлийн харилцаа, олон нийтийн оролцоог хангах, мэдээллийн хэт их эрэлт хэрэгцээг зохицуулах механизмууд.

Нөөц:

- Санхүүжилтийн эх үүсвэр, тасралтгүй байдал;
- Нөөцийн хадгалалт, ложистикийн механизм;
- Өртөмтгий бүлэг, хүн амд дэмжлэг үзүүлэх бусад нөөц, хангалт хийх салбар хоорондын байгууллагын чадавх.

Эрсдэл тус бүрээр даван туулах чадавхын түвшнийг хэлэлцэж тодорхойлсны дараа багаас их рүү эрэмбэлэх ба даван туулах чадавх өндөр байх тусам оноо нь бага байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Даван туулах чадавхын түвшнийг тогтоох

Оноо	Түвшин	Тодорхойлолт
1	Маш өндөр	Тухайн эрсдэлийн үед шаардлагатай бүх чадавх бүрдсэн, тогтвортой байх
2	Өндөр	Тухайн эрсдэлийн үед шаардлагатай бүх чадавх бүрдсэн хэдий ч бодит нөхцөл байдалд ашиглагдаж байгаагүй, түүнтэй адилтгах дасгал сургуулилтын үеэр туршиж үзээгүй байх
3	Дунд	Эрсдэлийн үед шаардлагатай зарим чадавх байгаа хэдий ч бүрэн ажиллагаатай эсэх, тогтвортой байдал хангагдаагүй. Жишээ нь: үндэсний хэмжээний эрүүл мэндийн салбарын төлөвлөгөө болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, тогтвортой санхүүжилттэй эсэх нь тодорхойгүй байх
4	Бага	Хүний нөөцийн болон эд материалын нөөц, санхүүжилтийн тогтвортой байдал зэрэг эрсдэлийн үед шаардлагатай үндсэн чадавх нь зөвхөн бүрдэж эхэлж байгаа үе. Тухайлбал: зарим нь хэрэгжиж, тодорхой түвшинд хүрсэн, зарим нь эхлэх шатанд байгаа үе.
5	Маш бага	Эрсдэлийн үед шаардлагатай үндсэн чадавхын ихэнх нь бүрдээгүй эсхүл аль нь ч бүрдээгүй байх.

Дэд алхам 3.4. Эрсдэлийн хүндрэл, өртөмхий байдал, даван туулах чадавхын оноог нэгтгэн нөлөөллийн үнэлгээний оноог тооцож гаргана (Хүснэгт 6).

Нөлөөллийн үнэлгээний оноо =
$$\frac{\text{хүндрэл} + \text{өртөмхий байдал} + \text{даван туулах чадавх}}{3}$$

3

Хүснэгт 6. Нөлөөллийн үнэлгээний оноо

Оноо	Нөлөөллийн үнэлгээ
1	Үл ялиг
2	Бага
3	Дунд
4	Хүнд
5	Маш ноцтой

АЛХАМ 4: Эрсдэлийн түвшнийг эцэслэн тогтооход цуглуулсан мэдээ,

мэдээлэл дээр үндэслэн эрсдэлийн үнэлгээний итгэх түвшнийг тогтоож, эрсдэлийн түвшнийг 3 дэд алхмаар тодорхойлно.

Дэд алхам 4.1.Эрсдэлийн итгэх түвшнийг тодорхойлох нь ямар төрлийн мэдээ, мэдээлэл хэрэгтэй болон цаашид үнэлгээг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд туслах бөгөөд эрсдэл тус бүрээр байгаа мэдээ, мэдээллийг хэлэлцэж, итгэх түвшнийг тогтооно (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Эрсдэлийн итгэх түвшний тодорхойлолт

Итгэх түвшин	Тодорхойлолт
Сайн	Нотолгоо сайтай, итгэж болохуйц олон эх үүсвэрт мэдээлэл, баталгаажсан, мэргэжилтнүүдийн санал нэгдсэн, өмнө нь тохиож байсан ижил төстэй үйл явдлын туршлага байгаа
Хангалттай	Хангалттай, чанартай нотолгоо, итгэж болохуйц мэдээллийн эх үүсвэртэй, таамаглал үнэн зөв, мэргэжилтнүүдийн санал нэгдсэн
Хангалтгүй	Нотолгоо хангалтгүй, мэргэжилтнүүдийн үзэл бодол тодорхой бус, зөрчилдөөнтэй, өмнө нь үүнтэй ижил төстэй үйл явдал тохиолдож байгаагүй

Дэд алхам 4.2.Эрсдэлийн матрицыг ашиглан эрсдэлийг эрэмбэлэхдээ маш бага, бага, дунд, өндөр, маш өндөр гэсэн ангиллын дагуу эрсдэл тус бүрээр түвшнийг тогтоож, 1-4 дүгээр алхмын дүнд үндэслэн эрсдэлийн түвшнийг тооцно.

Дэд алхам 4.3.Үндэсний болон орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, эрсдэлийн матриц дээр дүрслэн харуулна. (Зураг 4-өөр жишээ харуулав).

АЛХАМ 5:Эрсдэлийн зураглалын тайлан, цаашдын зөвлөмжийг 2 дэд алхмаар боловсруулна.

Дэд алхам 5.1.Цаашдын арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулахдаа эрсдэлийн түвшин бүрд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний зөвлөмж, тэргүүлэх чиглэлийн арга хэмжээг тодорхойлж, нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг дараах загвараар боловсруулна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрсдэлийн төрөл	Тэргүүлэх чиглэлийн арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага	Хамрах хүрээ	Санхүүжилт	Хугацаа

Дэд алхам 5.2.Эрсдэлийн зураглалын тайланг бичиж, баталгаажуулсны дараа салбар хоорондын байгууллагад илгээнэ (Загвар 1).

АЛХАМ 6.Үндэсний болон орон нутгийн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд цаашдын зөвлөмжийг заавал тусгана.

Загвар 1. Эрсдэлийн зураглалын тайлангийн загвар

Ерөнхий мэдээллийн хэсэг:

- Улс, орон нутгийн нэр
- Үнэлгээ хийсэн огноо
- Чиглүүлэгч байгууллага, албан тушаалтны нэрс
- Оролцогч байгууллага, албан тушаалтны нэрс

Тайлангийн хэсэг:

- Зорилго, зорилт
- Эрсдэлийн зураглал гаргасан аргачлал
- Эрсдэлийн зураглал боловсруулах үеийн зохион байгуулалт, үйл ажиллагаа
- Эрсдэлийн зураглалын үр дүн, зураглал
- Дүгнэлт
- Зөвлөмж
- Холбогдох бусад мэдээлэл

Зураг 4. МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
НОЦТОЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН МАТРИЦ

Нөлөөллийн түвшин	Ноцтой		Цар тахлын шинж чанартай амьсгалын замын эмгэг төрүүлэгчид (томуу, коронавирус, ортопокс вирус гэх мэт)			
	Хүнд				Улаанбурхан Галзуу	
	Дунд		Хумхаа Холер/Цочмог усархаг суулгалт Лептоспироз Хоол хүнсээр дамжих өвчин	Хачигт энцефалит Цар тахлын шинж чанартай амьсгалын замын эмгэг төрүүлэгчид (томуу, коронавирус, ортопокс вирус гэх мэт) Менингококкт халдвар Цацраг идэвхт бодис Цөмийн бодис Денгийн чичрэг өвчин Крым-Конгийн цусархаг халууралт өвчин Хачигт боррелиоз	Тарваган тахал Боом Хачигт риккетсиоз	Улирлын томуу КОВИД- 19
	Бага	Улаанууд Халдварт саа		Салхин цэцэг		
	Маш бага	Гахайн хавдар				
		Маш бага	Бага	Болзошгүй	Өндөр	Маш өндөр
Магадлалын түвшин						

Зураг 6. МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
НОЦТОЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ

Эрсдэл	Эрсдэлийн түвшин	Өртсөн газар нутаг	Магадлал	Нөлөөлөл	Өртөмтгий байдал	Даван туулах чадавх	Итгэх түвшин
Тарваган тахал	Өндөр	18 аймаг, нийслэлийн 132 сум, дүүргийн 443,3 км2 тарваган тахлын байгалийн голомттой.	Магадлалтай	Дунд	Дунд	Өндөр	Сайн
Боом	Өндөр	19 аймаг, нийслэлийн 157 сум, дүүрэгт боомын байгалийн голомттой.	Магадлалтай	Дунд	Дунд	Өндөр	Сайн
Галзуу	Өндөр	21 аймаг, нийслэлийн 94 сум, дүүрэгт галзуу өвчний эрсдэлтэй.	Магадлалтай	Хүнд	Өндөр	Дунд	Хангалтгүй
Улирлын томуу	Өндөр	Улсын хэмжээнд	Маш өндөр магадлалтай	Дунд	Дунд	Өндөр	Сайн
КОВИД-19	Өндөр	Улсын хэмжээнд	Маш өндөр магадлалтай	Дунд	Дунд	Өндөр	Сайн
Улаанбурхан	Өндөр	Улсын хэмжээнд	Маш өндөр магадлалтай	Дунд	Дунд	Дунд	Сайн
Хачигт риккетсиоз	Өндөр	21 аймагт хачгийн тархалттай, хачгийн халдварлалт 50-100% байна.	Бага магадлалтай	Дунд	Өндөр	Өндөр	Хангалттай
Хачигт энцефалит	Дунд	15 аймаг, нийслэлийн 72 сум, дүүрэгт хүний өвчлөл бүртгэгдсэн.	Бага магадлалтай	Дунд	Өндөр	Өндөр	Сайн
Цар тахлын шинж чанартай амьсгалын замын эмгэг төрүүлэгчид (томуу, коронавирус, ортопокс вирус г.м)	Дунд	Зөвөрлөгдөн орж ирдэг.	Магадлалтай	Дунд	Дунд	Дунд	Хангалттай
Менингококкт халдвар	Дунд	Улсын хэмжээнд	Very unlikely	Дунд	Өндөр	Дунд	Хангалттай
Цар тахлын шинж чанартай амьсгалын замын эмгэг төрүүлэгчид (томуу,	Дунд	Улсын хэмжээнд	Гарцаагүй тохиолдоно	Хүнд	Маш өндөр	Өндөр	Хангалттай

